



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ТБХ-09-2015



Батлав:

Нийслэлийн байгаль орчны газрын,  
Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн  
Хэлтсийн дарга

Ч.МӨНХБАЯР

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ДЦС-3” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал



Л.ЭРХБААТАР

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ  
“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН  
(ТӨСЛИЙН БАЙРШИЛ, НЭР)**

**2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 2546191/

Хянасан:

Нийслэлийн байгаль орчны газрын,  
Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн  
хэлтсийн мэргэжилтэн

Ж.БАТЗОЛБОО

Биелэлтийг тайлагнасан:

“ДЦС-3” ТӨХК-ийн Үйлдвэрлэлийн  
экологийн инженер

Э.ЭНХБАТ

2022 он



**“ДЦС-3” ТӨХК-ИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫГ  
ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

1. Төслийн үе шатны хэрэгжилтийн талаарх товч танилцуулга
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт
9. Дүгнэлт
10. Тайлангийн хавсралтууд:

Улаанбаатар хот



## 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“ДЦС-3” ТӨХК-ийн үйлдвэрийн хүчин чадал, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээллийг товч оруулсан болно.

### Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч-“Дулааны гуравдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компани

Тусгай зөвшөөрөл-Дулаан, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх, худалдах

### Хүчин чадал

1966 оны 12-р сарын 3-ны өдөр Дулааны 3-р цахилгаан станцын суурь тавигдаж, 1968 оны 12-р сарын 10-нд анхны зуух ашиглалтад орж, нийслэл хотын албан байгууллага, орон сууцанд дулааны эрчим хүч түгээж эхэлжээ. Өнөөдрийн байдлаар уг станцын суурилагдсан хүчин чадал цахилгаанаар 198 МВт, дулаанаар 585 Гкал байна.

### Үндсэн үйл ажиллагаа

Тус цахилгаан станц дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Цахилгаан үйлдвэрлэх
2. Цахилгаан түгээх
3. Дулаан үйлдвэрлэх
4. Дулаан түгээх
5. Цахилгаанаар зохицуулалттай хангах
6. Дулаанаар зохицуулалттай хангах

### Ажиллах горим, ажилчдын тоо

Станц нь 993 ажилтнаас Удирдлага -1 ИТА 220, ажилчид 772, үүнээс 230 эмэгтэй ажилтантай, Боловсролын хувьд дээд боловсролтой 383, тусгай дунд 97, бүрэн дунд 434 ажиллаж байна. Үйлдвэр нь өдрийн болон ашиглалтын 4 ээлжийн зохион байгуулалтаар ажилладаг. Тоног төхөөрөмжийн 24 цагийн тасралтгүй үйл ажиллагааг зуны улиралд ашиглалтын нэг ээлжинд 85-90 хүн, өвөл ашиглалтын нэг ээлжинд 120-135 хүн тус тус ажилладаг.

### Монгол Улсын эрчим хүчний системд нийлүүлж буй бүтээгдэхүүний хувь хэмжээ:

Монгол улсын төвийн эрчим цахилгаан эрчим хүчний хэрэглээний 16.1 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 31.4 хувь, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 47.5 хувийг хангадаг улсын онц чухал объект юм.

### Цахилгаан эрчим хүч:

Станц нь технологийн хэрэглээний усыг Сонсголонгийн гүүрний баруун талд байрлах өөрийн эзэмшлийн худгуудаас татан авч ашигладаг, станцын дулаан цахилгааны эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай нүүрсийг дан ганц Багануурын уурхайгаас хүлээн авч хэрэглэдэг. Дунд болон өндөр даралтын зуухнуудад хэт ханасан уурыг боловсруулан, турбингенераторт өгч, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн 35/110



киловольтын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний систем ба 6 киловольтын шугамаар хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Дулааны эрчим хүч: Ус, уураар

Дулаацуулгын улиралд Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн 31% 7000-8500 тн усыг халаан өгч байна. Мөн хүнс, ноос ноолуур, арьс шир, барилгын материалын 82 үйлдвэр, аж ахуйн нэгж газруудыг технологийн уураар ханган ажиллаж байна.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн схем, ачаалал:



Зураг-1 Улаанбаатар хотын дулаан хангамжийн ерөнхий схем

Үйлдвэрийн технологийн уурын хэрэглэгчид: 2022 он

№	Хэрэглэгчийн нэр	№	Хэрэглэгчийн нэр
1	"Агар тайж" ХХК	42	"Мон хими" ХХК
2	"Ай Ви Ко" ХХК	43	"Мон энзим" ХХК
3	"Алтай гацуурт" ХХК	44	"Монгол дээвэр" ХХК
4	"Алтайн Харгиа" ХХК	45	"Монгол нэхмэл" ХХК
5	"Алтан эвт холдинг" ХХК	46	"Монгол технологи инвестмент" ХХК
6	"АПУ" ХК	47	"Монгол шевро" ХХК
7	"АПУ" ХК - Спиртийн үйлдвэр	48	"Мон ирээдүй" ХХК
8	"АПУ" ХК - Пивоны үйлдвэр	49	"Монфрэш сүү" ХХК



9	"АПУ Дэйри" ХХК	50	"Наран золбоот кашмир" ХХК
10	"Атар өргөө" ХК	51	"Натур өргөө" ХХК
11	"АТТА ЧР" ХХК	52	"ОБ Пластик" ХХК
12	"А Үйлс" ХХК	53	"Оргил хүнс" ХХК
13	"Бауплюс" ХХК	54	"Пирамид индастри" ХХК
14	"Баянгонгор" ХХК	55	"Прогласс констракшн" ХХК
15	"Би Ай Ви" ХХК	56	"Прост" ХХК
16	"Би Ти Өү" ХХК	57	"Пэк солюшн" ХХК
17	"Би Цэ трейд" ХХК	58	"Сан индустриал" ХХК
18	"Буурал гол" ХХК	59	"Смарт крафт" ХХК
19	"Бэлон" ХХК	60	"Сопрема" ХХК
20	"Витафит инвест" ХХК	61	"Сор" ХК
21	"Ганбармат" ХХК	62	"Суурь" ХК
22	"Говь" ХК	63	"Ти Эс Ар Ананд" ХХК
23	"Говь" ХК - Гоёо үйлдвэр	64	"Ти Эс Жи" ХХК
24	"Денимон" ХХК	65	"ТНГРИ инвест" ХХК
25	"Довцог өндөр" ХХК	66	"Түмэн шир групп" ХХК
26	"Дулаан хөөс" ХХК	67	"УБ барилга" ХХК
27	"Жем интернэшнл" ХХК	68	"УБ хивс" ХК
28	"Жи Эн Бевереджис" ХХК	69	"Урбан бизнес групп" ХХК
29	"Жи Эс Эф" ХХК	70	"Хаалга цонх" ХХК
30	"Залуу хүнс" ХХК	71	"Хөнгөн бетон" ХХК
31	ЗХ-ний 011-р анги	72	"Хөнгөн тавцан" ХХК
32	"Их асар" ХХК	73	"Эвтэй намсрай" ХХК
33	"Их эргэлт" ХХК - 1	74	"Экопак монгол" ХХК
34	"Их эргэлт" ХХК - 2	75	"Элит фур" ХХК
35	"Кашмир концепт" ХХК	76	"Эм Кэй Вай Кашемир" ХХК
36	"Кашмер холдинг" ХХК	77	"Эм Ди Си Пи" ХХК
37	"Лиф" ХХК	78	"Эм Эн Ти Прожект" ХХК
38	"Лоро пьяна монгол" ХХК	79	"Эн Өү Ти Эс" ХХК
39	"Мод трейд" ХХК	80	"Эртний хүнс" ХХК
40	"Модкон" ХХК	81	"ЭХБУТрест" ХХК
41	"Мон Ит Булигаар" ХК	82	"Яармаг" ХХК



“ДЦС-3” ТӨХК-ийн 2022 оны эхний 10-н сарын ТЭЗҮ-н товч мэдээлэл:

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2021 оны мөн үеийн гүйцэтгэл	2022 оны эхний 9 сар			АТ-гай харьц		ГНТ-гай харьц		Өмнөх онтой		
				анхны төлөв	гүйц.ноог төлөв	гүйцэтгэл	зөрүү /6-4/	харьцаа /6-4/ %	зөрүү /6-5/	харьцаа /6-5/ %	зөрүү /6-3/	харьцаа /6-3/ %	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Боловруулсан ЦЭХ	мян.кВтц	777167.148	725688.00	735777.760	<b>736979.319</b>	11291.3	1.6%	1201.6	0.2%	-40187.8	-5.2%	
2	Догоод хэрэгцээний ЦЭХ	мян.кВтц	123797.477	121179.00	122843.953	<b>123328.708</b>	1149.7	0.9%	-515.2	-0.4%	-1468.8	-1.2%	
		хувь	15.93%	16.70%	16.70%	<b>16.60%</b>	-0.10%	-0.6%	-0.10%	-0.6%	0.67%	4.2%	
3	Түгээсэн ЦЭХ	мян.кВтц	653369.671	604509.00	612933.807	<b>614650.611</b>	10141.6	1.7%	1716.8	0.3%	-38719.1	-5.9%	
4	Түгээсэн ДЭХ	ус	Гкал	1301539	1333303	1396462	<b>1396462</b>	63159.0	4.7%	0.0	0.0%	94923.0	7.3%
		уур	Гкал	206301	191500	196224	<b>196224</b>	4724.0	2.5%	0.0	0.0%	-10077.0	-4.9%
		нийт	Гкал	1507840	1524803	1592686	<b>1592686</b>	67883.0	4.5%	0.0	0.0%	84846.0	5.6%
5	Жиш.гүлшний хув-н зарцуулалт	цах	гр/кВтц	332.940	341.1	335.5	<b>335.4</b>	-5.7	-1.7%	0.0	0.0%	2.5	0.8%
		дул	кт/Гкал	175.864	176.4	176.4	<b>175.286</b>	-1.2	-0.7%	-1.1	-0.6%	-0.6	-0.3%
6	Жишмэл гүлшний зарцуулалт	цах	тжт	217533.153	206193.670	206203.786	<b>206180.074</b>	-13.6	0.0%	-23.7	0.0%	-11353.1	-5.2%
		дул	тжт	265174.972	269047.86	280897.518	<b>279176.107</b>	10128.3	3.8%	-1721.4	-0.6%	14001.1	5.3%
		нийт	тжт	482708.125	475241.53	487101.304	<b>485356.181</b>	10114.7	2.1%	-1745.1	-0.4%	2648.1	0.5%
7	Техникийн усны зарцуулалт	мян.тонн	5389.8	5140	3966.7	<b>3966.7</b>	-1173.3	-22.8%	0.0	0.0%	-1423.1	-26.4%	
8	Нүүрсний зарцуулалт	тонн	948692.4	949106.0	944415.1	<b>940961.8</b>	-8144.2	-0.9%	-3453.3	-0.4%	-7730.5	-0.8%	
9	Конденсатын алдагдал	хувь	6.7	=	7.00	<b>6.44</b>	=	=	-0.6	-8.0%	-0.3	-3.9%	

Станцын техникийн усны хэрэглээний гүйцэтгэл:

сар	2022 оны төлөвлөгөө		2022 оны ХБГүйцэтгэл	
	ЭХ-ний үйлдвэрлэлд ашиглах гүний усны хэмжээ, (мян.тн)	Дахин ашиглах усны хэмжээ, (мян.тн)	ЭХ-ний үйлдвэрлэлд ашигласан гүний усны хэмжээ, (мян.тн)	Дахин ашигласан усны хэмжээ, (мян.тн)
1 сар	680	210	590	267
2 сар	600	170	462	207
3 сар	600	140	440	195
4 сар	580	120	497	169
5 сар	540	80	473	108
6 сар	530	80	355	96
7 сар	530	80	314	75
8 сар	530	80	336	108
9 сар	550	110	501	123
10 сар	570	140	570	140
11 сар	620	180		
12 сар	670	210		
Нийт	7000	1600	5827	1877



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ТБХ-09-2015



Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	"Дулааны III Цахилгаан Станц" ТӨХК
Улсын бүртгэлийн дугаар	9012001004
Регистрийн дугаар	2546191
Улсад бүртгүүлсэн	2005.10.20
Үйл ажиллагааны чиглэл	Дулаан, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх, худалдах
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ДЦС-3 ТӨХК байр
Утас	(+976) 11-343024, 341901
Факс	(+976) 11-343024
Вэбсайт	<a href="http://tes3.energy.mn/">http://tes3.energy.mn/</a>

Төслийн байршил:

Дулааны III цахилгаан станц" ТӨХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт 85 га талбайг хамран байрлана. Тус үйлдвэрийн харьяанд алслагдсан үнс хадгалах сан болон техникийн усан хангамжийн насос станц мөн түүнчлэн ахуй үйлчилгээний, инженерийн, хими цех, лаборатори туршилтын төв зэрэг барилга байгууламж багтдаг.



Зураг-2 "ДЦС 3" ТӨХК-ийн ерөнхий харагдах байдал



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ТБХ-09-2015



### "Дулааны цахилгаан станц 3" ТӨХК-ийн байршлын тойм зураг




**Таних тэмдэг**

- Дулааны цахилгаан станц 3
- Дүүргийн хил
- Дулааны цахилгаан станцын талбайн хил



ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ ХХК



Зураг-3 ДЦС-3 ТӨХК-ийн байршиллын тойм байдал





## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улс нь цаг уурын эрс тэс уур амьсгалтай, өвлийн улиралд Улаанбаатар хотын дулаан хангамжийн асуудал хүндээр тавигддаг бөгөөд станцуудын хувьд сүүлийн жилүүдэд ямар ч нөөц хүчин чадалгүй эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Манай станцын хувьд хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх тал даар онцгой анхаарч дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүнд:

1. Зуны бага ачааллын үед Дунд даралтын станцыг гурван сарын хугацаанд бүрэн зогсоож байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилладаг.
2. Ажилтнуудын ажлын байранд дагалдан суралцах хөтөлбөрт байгаль орчны сөрөг нөлөөллийг таниулах, бууруулах боломжийн талаар үе шаттайгаар мэдээлэл, мэдлэг олгож хандлагыг нь өөрчлөх арга хэмжээ авч ажиллаж байна.
3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу улирал бүр хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатороор шинжилгээ хийлгэж холбогдох бүх татвар хураамжийг хугацаанд төлдөг. / Ус ашигласны төлбөр, Ус бохирдуулсаны төлбөр, Агаар бохирдуулсаны төлбөр гэх мэт /
4. Шинээр баригдсан үнс хадгалах санд ус, хий үл нэвтрүүлэх олон улсад ашигладаг геомембран доторлогоог давхарлан хийлгэж газрын доорх усны бохирдлыг хянах мониторингийн гурван цооногийг шинээр өрөмдүүлэн тоноглож газрын доорх усны бохирдлыг хянах улсын нэгдсэн сүлжээнд холбосон.
5. Станцын технологи үйл ажиллагаа, шат дамжлага бүрт ашиглаад гарсан хаягдал саарал усыг тунгаах санд хуримтлуулж тунгаагаад эргүүлэн ашиглаж байгаа нь Улаанбаатар хотын хэмжээнд тулгамдаж буй байгалийн нөөц баялаг цэвэр усны хэрэглээг бууруулж хамгаалахад чухал нөлөөтэй юм.
6. Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийн дунд явагдаж буй төсөл хөтөлбөрүүдэд оролцож байна. / Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн, Туул гол цэвэрлэх аян гэх мэт /
7. Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй талбай, нийтийн эзэмшлийн талбайд улирал бүр их цэвэрлэгээ хийсэн.
8. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.
9. Цаашид хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор олон улсын стандарт, шаардлагад нийцсэн шинэ станцыг Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрээр үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



## “ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТӨСЛИЙН ТЭЗҮ-Г ХҮЛЭЭН АВЛАА

2022.09.13

Монгол Улсын эрчим хүчний салбарыг найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх “ДЦС-3” ТӨХК-ийн өргөтгөлийн төслийн бэлтгэл ажил явагдаж байна.

2021 оны 06-р сарын 30-нд станцын өргөтгөлийн төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын даалгавар боловсруулж ТЗХ-р батлуулсан бөгөөд ажлын даалгаврын хүрээнд 2021 оны 9-р сард ОХУ-ын судалгааны баг “ДЦС-3” ТӨХК-ийн төслийн талбайд ирж нарийвчилсан судалгаа хийсэн.

2021 оны 12-р сарын 16-ны өдөр “ДЦС-3” ТӨХК-ий захирал Л.Эрхбаатар Москва хотод “ДЦС-3” ТӨХК “ИНТЕР-РАО ЭКСПОРТ” КОМПАНИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ САНАМЖ БИЧИГТ гарын үсэг зурж баталгаажуулсан.



Зураг-4 ОХУ-ын ИНТЕР-РАО ЭКСПОРТ ХХК-д очиж санамж бичиг зурав

Санамж бичгийн хүрээнд 2021 оны 12-р сарын 30-ны өдөр ОХУ-с ирсэн Техникийн үндсэн шийдэл ирэв. 2022 оны 01-р сарын 12-ны өдөр “ДЦС-3” ТӨХК-ийн зүгээс “ДЦС-3” ТӨХК-ийг 1-р шатанд Өндөр Даралтын Хэсэгт 50МВт-ын турбогенераторыг, 1х300 тн/ц-ийн зуухыг туслах тоноглолуудын хамт суурилуулах, 2-р шатанд Дунд Даралтын Хэсгийг буулгаж суурин дээр нь 2х125МВт-ын турбогенератор, 2х300 тн/ц-ийн зуухыг туслах тоноглолуудын хамтаар суурилуулан шинэчлэх төслийн хувилбарыг ОХУ-ын талд илгээсэн. 2022 оны 08-р сарын 29-ны өдөр ТЭЗҮ-г хүлээн авах хурал зохион байгуулж төслийн гүйцэтгэгч компани болох ОХУ-ын “ИНТЕР-РАО ЭКСПОРТ” ХХК төслийн ерөнхий захиалагч болох “ДЦС-3” ТӨХК-д өргөтгөлийн төслийн ТЭЗҮ-г хүлээлгэн өглөө.



Монгол Улсаас төслийн ТЭЗҮ хүлээн авах арга хэмжээнд:

- МУ-ын Эрчим Хүчний сайд Н.Тавинбэх
- МУ-ын Эрчим Хүчний сайдын зөвлөх Ц.Цэнгэл
- МУ-ын ЭХЯ-ны Бодлого Төлөвлөлтийн Газрын дарга Б.Ерэн-Өлзий
- “ДЦС-3” ТӨХК-ий захирал Л.Эрхбаатар
- “ДЦС-3” ТӨХК-ий ерөнхий инженер П.Болдбаатар

ОХУ-аас төслийн ТЭЗҮ хүлээлгэн өгөх арга хэмжээнд:

- Төслийн зохицуулагч А.В.Бунаков
- ОХУ-аас Монгол улсад суугаа ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн дарга Т.Б.Данзанов
- ОХУ-ын Монгол дахь худалдааны газрын тэргүүн М.В. Васильев
- “Интер-РАО” ХХК-ийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч Н.Наранбат нар тус тус оролцсон юм.

Тухайн төсөл хэрэгжснээр хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө хамгийн бага тоног төхөөрөмжүүд суурилагдаж цахилгаан эрчим хүч 252 МВт-р нэмэгдэн 84 мянга орчим айл өрхийг цахилгаанаар хангах боломж бүрдэх бөгөөд дулааны эрчим хүч 340 Гкал-р нэмэгдэн 34 мянга орчим айл өрхийг дулаанаар хангах боломж бүрдэнэ..




Зураг-5 ОХУ-ын “Интер-РАО” ХХК-ийн төслийн зохицуулагч А.В.Бунаков төслийн ТЭЗҮ-ийг “ДЦС-3” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатарт хүлээлгэн өгөв.



## ҮНС ХАДГАЛАХ САНГИЙН УСЫГ ЦЭВЭРШҮҮЛЭХ 150 М<sup>3</sup>/Ц ХҮЧИН ЧАДАЛТАЙ ЦЭВЭРЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Үнс хадгалах сан, тунгаах сангийн усыг цэвэршүүлэн дахин ашиглах зорилгоор усанд агуулагдах бохирдлыг цэвэрлэх DLD-FL-200 маркийн 1 дүгээр шатны торон шүүлтүүр, BS 483S84 маркийн 2 дугаар шатны элсэн шүүлтүүрүүдээр тоноглогдсон цагт 150 м<sup>3</sup> ус цэвэрлэх хүчин чадалтай байгууламжийг барьж ашиглалтанд оруулсан. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам хоолойн усралтуудыг хийж туршилтыг хийж гүйцэтгэн станцад хүлээлгэн өгсөн.



Зураг-6 "ДЦС-3" ТӨХК-д суурилагдсан 150 м<sup>3</sup>/ц хүчин чадалтай ус цэвэрлэх байгууламжийн загвар зураг

Төхөөрөмжийн техникийн тодорхойлолт:

### Нэгдүгээр шатны торон шүүлтүүр:

Марк: DLD-FL-200

Үзүүлэлтүүд:

Хамгийн их ачаалал: 175 м<sup>3</sup>/цаг  
Ажлын ачаалал: 150 м<sup>3</sup>/цаг  
Торны хэмжээ: 100 микрон  
Усны оролт, гаралтын шугам: 200 мм  
Угаалтын шугам: 50 мм  
Ажлын даралт: 2-10 атм  
Холболтын хэлбэр: фланц  
Материал: ган  
Удирдлагын хэлбэр: автомат  
Угаалт: автомат  
Цэвэрлэх хугацаа: 10-200 секунд




Зураг-7. Автомат торон шүүлтүүр



Хоёрдугаар шатны элсэн шүүлтүүр:

Марк: BS 483S84



Үзүүлэлтүүд:

Хамгийн их ачаалал: 175м3/цаг  
Ажлын ачаалал: 150 м3/цаг  
Шүүлтүүрийн тоо: 3  
Усны оролт, гаралтын шугам: 200мм  
Угаалтын шугам: 100мм  
Ажлын даралт: 2-10атм  
Холболтын хэлбэр: фланц  
Материал: ган  
Удирдлагын хэлбэр: автомат  
Угаалт: автомат  
Хүчдэл: 220/380 В

Зураг-8. Автомат элсэн шүүлтүүр

Гадны итгэмжлэгдсэн лабораториудад хийлгэсэн шинжилгээний дүнг "Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015"-д харьцуулах жинлэгдэх бодисын хэмжээ 2..3 дахин бага гарсан.



Зураг-9 Ус цэвэрлэх төхөөрөмжүүд



Зураг-10 Байгууламжийн барилга.

Ус цэвэрлэх тоног төхөөрөмжийг шинээр суурилуулан ашиглаж тунгаагдсан саарал усанд агуулагдах бохирдлыг бүрэн цэвэрлэж байгальд орчинд нийлүүлэх нь байгаль экологид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, саарал усны дахин ашиглалтыг сайжруулснаар гүний цэвэр усыг хэмнэж эдийн засгийн бодит үр өгөөжийг өгөх урьд өмнө хийгдэж байгаагүй шинэ техник ,технологи гэдгээрээ чухал ач холбогдолтой.



## БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДАД БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААРХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Байгууллагын зорилтот түвшинг хангах ажлын хүрээнд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудад 2022 оны 10-р сард байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандарт, нормт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх тал дээр анхаарах мэдээлэл өгөх сургалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж ажилтнуудын санал хүсэлтийг сонсож зөвлөгөө өгөх сургалтыг амжилттай зохион байгуулсан.



Зураг-11 4-н ээлжийн ажилтнуудын байгаль орчны талаарх сургалт явуулсан байдал



Зураг-12 Байгууллагын алба, хэлтэс, цехийн ИТА нар сургалтанд хамрагдав



## БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫГ ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, ХЭРЭГСЛЭЭР ХАНГАСАН БАЙДАЛ

Компани нь ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн тал дээр онцгой анхаардаг бөгөөд жил бүр тодорхой судалгаа хийж ажлын байрны нөхцөл байдалд нийцсэн хувцас хэрэглэлээр ханган ажилладаг. Компанийн дотоод хяналтын хэлтсээс 2022 оны 7-р сард ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нормд өөрчлөлт оруулахаар судалгаа хийж цех, хэсэг, нэгжийн нийт ажилтнаас санал авч ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хугацаа, нормыг 2022 оны 09-р сард батлуулж, 2023 оны 05-р сараас мөрдөж эхэлнэ.

Ажиллагсдын санал хүсэлтийн дагуу ажлын нимгэн дотуур цамц 727 ширхэгийг гэрээт нийлүүлэгч компанитай ярьж нэмэлтээр захиалгад оруулж, цехийн ашиглалтын ажилчдыг нимгэн цамцны нормтой болголоо. Үүнд: Нэмэлтээр Хими, Цахилгаан, Дулааны хянах хэмжүүрийн цехүүдийн ажилчдыг ажлын нимгэн цамцны нормтой болгосон.

Мөн ажилчдаас ажлын гутлыг хагас богино, болон богино түрүүтэй авах судалгааг авахад 637 ажилтан богино түрүүтэй гутал, 304 ажилтан хагас түрүүтэй гутал авах санал гаргасан тул саналын дагуу гэрээт компанид захиалга өгсөн.

Гэрээгээр нийлүүлэгдэж байгаа ажлын тусгай хувцас, гутал, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нийлүүлэлт, чанар, стандарт ашиглалтанд хяналт тавьж ажиллаж байна. Гэрээт компанид 2022 онд ажлын оёмол хувцас нийлүүлэлтийг. /хүснэгтээр харуулвал./

2022 оны ажлын хувцас нийлүүлэлт:

д/д	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Хэмжих нэгж	Нийлүүлэх тоо	Нийлүүлсэн тоо	Дутуу нийлүүлсэн	
1	Ажлын даавуун комбинзон	Монгол улс	ширхэг	133	133	0	
2	Ажлын өмд цамцны хослол	ИТА	Монгол улс	хос	244	244	0
3		Ажилчин	Монгол улс	Хос	1583	543	1040
4	Ажлын нимгэн цамц	Монгол улс	ширхэг	727	310	417	
5	Брезинтэн өмд цамц	Монгол улс	ширхэг	53		53	
6	Өвлийн куртка	Монгол улс	ширхэг	349		349	
7	Өвлийн өмд цамц	Монгол улс	хос	102	102	0	
8	Ханцуйвч	Монгол улс	хос	1057	1057	0	
9	Ус нэвтэрдэггүй комбинзон	Монгол улс	ширхэг	21		21	
10	Ажлын дохиочны цацруулагчтай хантааз	Монгол улс	ширхэг	28	28	0	
11	Гагнуурчны илгэн хувцас	Монгол улс	ширхэг	31	31	0	
12	Даавуун халаад	Монгол улс	ширхэг	22	22	0	
13	Брезинтэн хормогч	Монгол улс	ширхэг	1	1		
14	Ажлын хувцас	Монгол улс	хос	9		9	



	лаборант					
15	Сувлагчийн нимгэн өмд цамц	Монгол улс	хос	2		2
16	Эмнэлгийн халад	Монгол улс	ширхэг	2		2
17	Үйлчлэгчийн нимгэн өмд цамц	Монгол улс	хос	6		6

БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт
1	2	3	4	
<b>Агаарын чанар</b>				
1	Станцын үндсэн үйл ажиллагаанаас зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын хүрээнд нүүрс хадгалалт, тээвэрлэлт, бутлуур цех, конвейер, зуухны яндан, тээврийн хэрэглэлийн хөдөлгөөн, үнсэн сан, зам харгуй, ахуйн хог хаягдлын цэг зэргээс агаар дахь тоосжилт, PM, CO, SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> ихсэж орчны хүчилтөрөгчийн (O <sub>2</sub> ) хэмжээ багасаж болно.	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглагдах утааны яндангаас гарах агаар бохирдуулагчдад тогтмол хэмжилт хийх замаар хяналт тавих, зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдлуудад дүгнэлт хийж шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагааны үед	1. Тус станц нь одоо мөрдөгдөж буй MNS 5919:2008 стандартыг мөрдөн ажиллаж яндангаар хаягдах утааны хийн найрлагыг суурин болон зөөврийн төхөөрөмжөөр тогтмол хянан ажиллаж байна. Хяналтын тоног төхөөрөмжийн хэмжилт, хөндлөнгийн хэмжилтээр стандарт хэмжээнээс хэтрээгүй болно. Жич: хэмилтийн дүнгүүд хавсаргав.
2		Үнсэн сангийн тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөх	Үнсэн сангуудыг хамруулах	2. Станцын үнс баригч төхөөрөмж нь нойтон буюу усаар үнсээ барих технологитой тул одоо ашиглаж буй үнс хадгалах сангийн дээд хэсэгт усан үе үүсдэг тул үнс хийсэх боломжгүй юм. Хуучин үнс хадгалах сангуудад техникийн нөхөн сэргээлт хийж шаардлагатай үед усан толио үүсгэх төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авч үнсний хийсэлтгүй ажиллаж байна.
3		Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол	Дулааны улиралд	3. Станц нь үйлдвэрийн эзэмшил талбайд усалгааны систем тоног төхөөрөмжөөр суурилуулан хур бороо багатай саруудад







		хийж байх		зориудаар усалгаа хийж тоосролтыг бууруулан ажиллаж байна.
4		Хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Ахуйн хатуу хог хаягдлын орчимд	4. Үйл ажиллагаанаас гарсан ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ангилан ялгаж ХУД-н тохижилт үйлчилгээний төвтэй гэрээ байгуулан Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт нийлүүлж төлбөрийг төлдөг.
5		Бохирдол ихтэй газар ажиллаж буй ажилчдад хувийн хамгаалах хэрэглэлийг тараах, тогтмол хангаж хэвшүүлэх	Техник хяналтын хэлтэс, холбогдох цех нэгжүүд зохион байгуулах	5. Компанийн бизнес төлөвлөгөөнд ХАБЭА-н зардлыг тусгаж шаардлагатай нэгж хэсгүүдийг хангаж ажилласан.
6		Агаар бохирдуулагчид ихээр буй үүсэж цех, дамжлагуудад агааржуулалтыг тогтмол хийж байх	Дотоод үйл ажиллагаагаар	6. Түлш дамжуулах цехийн конвееруудад тоос намжаах буюу аспирацын төхөөрөмжөөр бүрэн тоноглож конвер ажиллах бүрт хамт ажиллах тохиргоо хийж тоосролтыг бууруулан ажилладаг.
7		Ахуйн хог хаягдал болон сэлбэг материалын хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн цэгт цуглуулах, хоёрдогч түхий эд болгож ашиглахаар ялгасан зүйлийг холбогдох цэг, үйлдвэрт тээвэрлэж хүргэх, борлуулах	Станцын хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгах талаар шат дараатай мэдээлж хэвшүүлэх талаар анхаарах.	7. Станцын ажлын байрууд болон хашаанд нэгдсэн хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай хогийн савыг шинээр хийн байршуулах ажил хийгдэж байна. Ажилтнуудад хог хаягдлыг ангилан ялгаснаар гарах эерэг үр дүнгийн талаар мэдээлэл, сургалтыг ажлыг зохион байгуулсан.
<b>Газрын гадарга, хөрс, ургамал</b>				
8	Станцын дүүрсэн үнс хадгалах сангуудын үнсийг суллах, ашиглах боломжийн талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Үнс хадгалах сангууд	"ДЦС-3" ТӨХК-ийн эзэмшил сангуудын хүрээнд	8. Станц нь 2020 онд өөрийн эзэмшлийн сүүлийн 9.3 га газарт үнс хадгалах сан байгуулсан бөгөөд өмнө нь дүүргээд нөхөн сэргээлт хийсэн үнс хадгалах сангуудыг суллаж дахин ашиглах боломжийн талаар "Эко Гидро Проект" ХХК мэргэжлийн байгууллагаар ажлын зураг, төсөв хийлгэх ажлыг гүйцэтгүүлж байна. Мөн Цөмийн энергийн комисс, Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн байгаль орчны газар, Эрчим хүчний зохицуулах хороо, хувийн хэвшлийн цементны үйлдвэрүүд



				ОХУ-ын судлагааны газруудтай уулзалт зохион байгуулж үнсийг ашиглах боломжийн талаар мэдээлэл солилцон ажиллаж байна.
9	Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй	Төслийн газар ашиглалттай холбоотой бичиг баримтыг бүрдлийг хангах онц шаардлагатайгаас бусад талбайд ашиглалт явуулахгүй байх арга хэмжээ авах	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	9. Станцын өргөтгөл шинэчлэлийн ажилтай холбоотой Нийслэлийн газрын албанд нэмэлтээр шаардлагатай газар эзэмших албан хүсэлт хүргүүлсэн.
10		Дахин ашиглагдахгүй болсон талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	10. Хуучин ашиглаад дүүргэсэн үнс хадгалах сангууд болон техникийн усны шугам, тунгаах сангийн газруудад тэмдэг, тэмдэглэгээ байршуулж өөрөөрөө нөхөх сэргэх нөхцлийг бүрдүүлэн хяналт тавин ажиллаж байна.
11		Орчныг байнга чийглэж ургамал нөмрөгийг сэргээн сайжруулах зорилгоор бороожуулалтын (шүршүүр) систем бий болгох	Бүх нэгжүүд	11. Цех нэгжүүд эзэмшил талбайдаа тогтмол арчилгаа, усалгаа хийж нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байна.
<b>Усан орчин</b>				
12	Үйл ажиллагаанд ашиглаад гарсан саарал ус агуулах, хадгалах байгууламжуудын ус үл нэвчүүлэх хамгаалалт хагарах, цоорох, бохир ус дамжуулах хоолойд гэмтэл үүсэх, шатах тослох материал асаралт зэрэг нь бохирдлын эх үүсвэр болно.	Шинэ үнс хадгалах сангийн ойролцоо газрын доорх усанд хяналт хийх зориулалттай цооногийн мэдээллийг хянаж ажиллах.	Дотоод зохион байгуулалтаар	12. Үнс хадгалах сангуудын хажууд байрлуулсан газрын доорх усны бохирдлыг хянах зориулалттай бүрэн автомат нэг, хагас автомат хоёр хяналтын цооногийн мэдээллийг сар бүр тогтмол хянаж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан. Жич: 2020 оноос хойш хяналтын цооногуудын мэдээлэлд бохирдол үүссэн талаарх мэдээлэл бүртгэгдээгүй болно.
13		Тунгаах сангийн усанд сар бүр дотоод хяналтын лаборатороор дээж авхуулж хяналт тавьж	Дотоод төлөвлөлтөөр	13. Тунгаах сангийн усанд дотоод хяналтын лаборатороор сард хоёр удаа, итгэмжлэгдсэн лабораторуудад улиралд нэг удаа, шаардлагатай үед тухай бүрт нь шинжилгээ хийлгэн



		ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ		АШБ-ТБХ-09-2015
				
		ажиллах.		хаягдал усны дүгнэлт гаргуулсан.
14		2022 оны Ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, 2022 оны ус ашиглалтын гэрээ байгуулах	Ашиглах усны хэмжээгээр	14. Усны тухай хуулийн 28 болон 18.1.4 дэх заалтын дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр ус ашиглах №09 тоот дүгнэлтийг гаргуулж Туул голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна.
	Нийт зардал	6 500.0		

### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус станц нь үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нийт 85 га талбайд үйл ажиллагаа явуулж байна. Тус 85 га талбайгаас барилга байгууламж, тоног төхөөрөмжүүд байрласан 42 га талбайн тохижилт, нөхөн сэргээлт, арчилгааны ажлыг сар бүр сайжруулах ажил хийгдэж байдаг. Харин алслагдсан техникийн усны насос станц, тунгаах усны насос станцын орчны тохижилтын ажлыг техник ашиглалтын дүрэмтэй уялдуулж хийж байна. Станцын хувьд гол анхаарал хандуулж хөрөнгө зарцуулж нөхөн сэргээлт, усжуулалт хийж буй газар нь хуучин үнс хадгалах сангийн газрууд юм. Өнөөгийн байдлаар хуучин үнс хадгалах сангуудад техникийн нөхөн сэргээлт хийсэн шаардлагатай тохиолдолд усалгаа хийж хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг-13 Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн үнс хадгалах сан № 4

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		

БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Биелэлт
	1	2	3	4
1	Төслийн талбайн орчим нөлөөлөгд өртсөн талбайг нөхөн сэргээх	Станцын эзэмшил газар мод, сөөг огтлох, хөрс эвдэх, хог хаягдал асгах явдалд хяналт тавьж тохижуулалт хийх, ургамалжуулах	Дулааны цахилгаан станцын эзэмшлийн талбайд	1. Станцын үндсэн үйл ажиллагаа явуулж буй газар нь бетон хашаатай тул хог хаягдал асгах боломжгүй алслагдсан аж ахуйн орчим барилгын хог хаягдал асгах явдал гарч холбогдох хяналтын байгууллагуудад зөрчил арилгуулахаар хандан ажилласан. 2. Ногоон байгууламжийн арчилгааг хариуцсан цех нэгжүүд тогтмол хийж ажилладаг. 3. Үйл ажиллагаанд ашиглагдаад гарсан усыг эргүүлэн усалгаанд ашигладаг.
2		Ногоон байгууламж байгуулах талбайн хөрсийг үржил шимт хөрсөөр хучих, бэлтгэх	Ногоон байгууламжийн орчимд	
3		Ногоон байгууламж-ийн арчилгаа усалгаа	Ногоон байгууламж-ийн орчимд	
	Нийт			

#### 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын хөдөлмөрийн сайдын 2015 оны 12-р сарын 28-ны А/295 тоот тушаалаар батлан гаргасан “**АЖЛЫН БАЙРНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ**”-ийн хүрээнд “**ДЦС-3**” ТӨХК-ийн ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмж, ажлын заавар-ыг гарган батлуулж, ажлын байруудад эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байна. Жилдээ давтагдсан тоогоор 60-80 ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийгддэг бөгөөд 2022 онд 63 ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж, төлөвлөгөөний дагуу эрсдэлийг бууруулах ажлууд хийгдэж байна.

Станцын хэмжээнд болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх гамшгийн эрсдэлийн үнэлгээг гадны байгууллагаар 2 жил тутамд хийлгэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гаргаж батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн Хан –Уул дүүргийн онцгой байдлын газраас Дунд даралтын хэсгийн МАА, өндөр даралтын хэсгийн МАА болон шатахуун түгээх станцад галын аюулгүй байдлын дүгнэлтийг жил бүр гаргуулган ажилладаг. Дүгнэлтийг хавсралтад тусгав.

ХАБ-г хангуулах, аливаа осол аваараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж ажилладаг. ХАБ-г хангуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2022 оны эхний 9 сарын байдлаар харуулбал:



АНХНЫ ТУСЛАМЖИЙН СУРГАЛТ, ДАСГАЛ



Зураг-14 ажлын байранд анхны тусламж үзүүлэх сургалт

ГАЛ, ГАМШГИЙН СУРГАЛТ, ДАСГАЛ



Зураг-15 Гэрээт галын хэсгийн ангитай хамтарсан сургалт хийж буй байдал



Байгууллагын ХАБ-г хангуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2022 оны эхний 9 сарын байдлаар харуулбал:

д/д	Үзүүлэлт			09-р сар	Өссөн дүн	
<b>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ</b>						
1	Урьдчилсан			75	1110	
2	Анхан шатны			15	493	
3	Зааварчилгаа авсан хүний тоо	Давтан	Өдөр тутмын	10460	90151	
4			Ээлжит	Сарын давтан	900	7667
5		Ээлжит бус			1066	13828
6		Тухайлсан			2517	23912
7	Мэдлэгийн шалгалт өгсөн хүний тоо	Анхны		10	201	
8		Ээлжит		84	1519	
9		Ээлжит бус		45	742	
10	III шатны үзлэг	Анхан шатны үзлэг	Үзлэгийн тоо	593	5019	
11			Илэрсэн зөрчлийн тоо	429	3696	
12			Арилгасан зөрчлийн тоо	395	3436	
13		II шатны үзлэг	Үзлэгийн тоо	28	299	
14			Илэрсэн зөрчлийн тоо	35	413	
15			Арилгасан зөрчлийн тоо	32	370	
16		III шатны үзлэг	Үзлэгийн тоо	18	55	
17			Илэрсэн зөрчлийн тоо	5	11	
18			Арилгасан зөрчлийн тоо	5	11	
19		Нийт	Үзлэгийн тоо	637	5365	
20			Илэрсэн зөрчлийн тоо	469	4105	
21			Үзлэгийн тоо	432	3769	
22	Гүйцэтгэсэн ажил	Наряд		411	3066	
23		Шийдвэр		827	6364	
24	Гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг	Үзлэгийн тоо		276	2283	
25		Хамрагдсан нэгжийн тоо		152	996	
26		Илэрсэн зөрчлийн тоо		189	1610	
27		Арилгасан зөрчлийн тоо		187	1531	
28	Дасгал	АЭД	Дасгалын тоо	15	76	
29			Хамрагдсан хүний тоо	378	1546	
30		ГЭД	Дасгалын тоо	7	43	
31			Хамрагдсан хүний тоо	281	1209	
32		Бусад	Дасгалын тоо	3	27	
33			Хамрагдсан хүний тоо	108	768	
34	Сургалт	Хугацаа /цагаар/		57	466,5	
35		Хамрагдсан хүний тоо		557	4053	
36	Эрсдэлийн үнэлгээ	Нийт ажилтны тоо		993	993	
37		Эрсдэлийн үнэлгээ хийвэл зохих ажлын байрны тоо		1	55	
38		Эрсдэлийн үнэлгээ хийсэн ажлын байрны тоо		2	55	
39		Эрсдэлийг дахин үнэлсэн ажлын байрны тоо		7	20	
40	Эрсдэл бууруулсан ажлын байрны тоо		36	941		





Хими цехийн аж ахуйнууд болон химийн бодис хадгалах агуулахад химийн бодисыг цэвэрлэх зориулалттай галын хор, элс, шороо, ус, хүрз зэрэг цэвэрлэгээний багаж хэрэгслийн булан хийж байрлуулсан. Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдалд тогтмол үзлэг хийж хяналтын картанд тэмдэглэл хийж байна.



Хүчлийн аж ахуйд аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. Хүчлийн аж ахуйд алдагдсан химийн бодисыг цэвэрлэх мөн хүчлийн баканд цэвэрлэгээ үйлчилгээ хийсний дараа саармагжуулах арга хэмжээ авах зорилготой угаалгын цэгийг бий болгосон.



Алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлийг жил бүр бизнес төлөвлөгөөндөө тусгаж оруулан нөхөн хангалт хийж ажиллаж байна. Аюултай хог хаягдал шилжүүлэх болон тээвэрлэх гэрээг 2022 оны 9-р сард "Цэцүүх" ХХК-тай хийж химийн аюултай хог хаягдлыг шилжүүлэх, хаях ажлыг хийж гүйцэтгэж байна.





БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлт
	1	2	3	4
1	Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Нөөцөд сав баглаа боодол байлгах (үйлдвэрт хадгалагдаж буй сав баглаа, боодлыг ариутгаж ашиглахаас гадна нөөцөд шинэ сав, баглаа боодол авч хадгалах)	Хадгалж байгаа химийн бодисын шинж чанарт тохирсон	Станц нь БОАЖЯ-аас олгосон дараах химийн бодисуудыг ашигладаг.  Үүнд: технологийн ус бэлтгэлд 10 нэр төрөл, усны шинжилгээ хийх зориулалтаар дотоод хяналтын лабораторт 46 нэр төрлийн химийн бодис ашигладаг бөгөөд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй зориулалтын агуулахад хадгалан сав баглаа боодлыг "Цэцүүх" ХХК-д өгч устгал хийлгэдэг.
2		Шаардлагатай үед алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис гэх мэт	Хими цех нь галын болон химийн бодис алдагдсан үед ашиглах боломжтой тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан.
	<b>Нийт</b>			

## 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компани нь хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, дагалдан гарсан журмуудын хэрэгжилтийг хангахаар байгууллагын хэмжээнд дээрх асуудлыг шийдвэрлэх үндсэн үүрэгтэй комиссыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж станцын бүх цех нэгжүүдийн ажлын байр болон хуваарьт талбайн хог хаягдалд хяналт тавьж долоо хоног бүр тогтмол үзлэг хийж биелэлтийг хангасан талаарх хурлыг хийж үнэлгээ өгч ажиллаж байна.





Үйл ажиллагаанаас гарсан үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрсөн цэг, талбайд зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж хаях гэрээ байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Станцын бүх ажлын байруудад ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллага болох "Цацу" ХХК-тай гэрээ графикийн дагуу улирал тутамд захиргаа, соёлын төвийн өрөөнүүдэд болон цех хэсгүүдийн ахуйн болон ариун цэврийн өрөөнүүдэд ариутгалыг графикын дагуу гэрээний дагуу 2442,1 м2 талбайд ариутгал, 1616 м2 талбайд мэрэгч, 7555 м2 талбайд шавьж устгалыг тогтмол хийлгүүлж байна.



Бүх нийтийн хавар, намрын их цэвэрлэгээ мөн УБ хотын захирагчын ажлын албанаас зохион байгуулдаг "Шарилжгүй Улаанбаатар аян 7", ХУДүүрэгийн нэрэмжит "Хоггүй Хан-Уул 2022" аянд нэгдэж станцын хашаан дотор, гадна талбай нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж зориулалтын хогийн цэгт тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн хаяж зайлуулан ажиллаж байна.



Мөн энэ жил нийгмийн хариуцлагын хүрээнд Туул гол цэвэрлэх сайн дурын аянд нэгдэж Яармагийн гүүрнээс Сонсголонгийн гүүр хүртэлх талбайд бүх алба, хэлтэс, цех, нэгжүүдээс бүрдсэн 100 хүний бүрэлдэхүүнтэйгээр зардлаа өөрсдөө хариуцан их цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.





БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт
	1	2	3	4
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх.	Гадаа талбайд байршуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. Станцын цех, нэгж бүр өөрсдийн хогийн сав ашиглаж графикийн дагуу ачуулж нэгдсэн хогийн цэгт нийлүүлдэг.</li> <li>2. Ажлын байруудын ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн.</li> <li>3. Үйл ажиллагаанд ашиглаад гарсан усыг тунгаах санд хуримтлуулж эргүүлэн ашиглах боломжтой бүх газарт ашигладаг.</li> <li>4. Химийн бодисуудын тусгай зөвшөөрөл, хадгалах агуулахын дүгнэлт гаргуулж, химийн сав баглаа боодлын хаягдлыг устгуулах гэрээг мэргэжлийн байгууллагатай хийсэн.</li> </ol>
2	Үйлдвэр, ахуйн	Ариутгал цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж байх	Хатуу хог хаягдлыг цуглуулж буй газар	
3	Үйлдвэрийн	Хаягдал усны дахин ашиглалтын хувь хэмжээг аль болох технологи үйл ажиллагаатай уялдуулж нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Шингэн хаягдлын орчимд	
4	Аюултай	Химийн бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу хэрэгжүүлэх.	Холбогдох ажилтан албан хаагчдад үүрэг өгөх	
	<b>Нийт</b>			

## 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ


Агаар бохирдуулах хорт бодисын хяналт, хэмжилтийн үр дүн:

Станцын яндангаар хаягдаж байгаа хорт бодисын хэмжээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа MNS 5919:2008 стандартын дагуу суурин болон зөөврийн төхөөрөмжөөр хэмжилт хийн хяналт тавин ажиллаж байна. Тус хэмжилтийн дүнг файл хэлбэрээр ЦУОШГазарт сар бүр мэдээг хүргүүлдэг бөгөөд хөндлөнгийн шалгалт хийхээр ирсэн НМХГазар, НАОБТГазарт шаардсан хугацаанд мэдээлэл хүргүүлдэг болно.





### “ДЦС-3” ТӨХК-ИЙН ЯНДАНГААР ХАЯГДАХ УТААНЫ ХИЙГ ХЯНАХ СУУРИН ТӨХӨӨРӨМЖҮҮД



ДЦС-3 ТӨХК-ийн ӨДХ-ийн яндангаар хаягдах утааны хийн хяналтын PS7400 маркын суурийн төхөөрөмж

### ДДСтанцын зуухнаас гарах утааны хийн (NOx, SO<sub>2</sub>, CO, O<sub>2</sub>) найрлагийг хэмжих зөөврийн багаж /TESTO-350/



ДЦС-3 ТӨХК-ийн ДДХ-ийн яндангаар хаягдах утааны хийн хяналтын зөөврийн төхөөрөмж TESTO-350



**“ДЦС-3” ТӨХК-ийн дунд даралтын станцын яндангаар хаягдах утааны хийн 2022 оны хэмжилт:**

Эх үүсвэрийн нэр, байршил	Хэмжилтийн цаг зууны хүчин чадал	Хэмжилт хийсэн он, сар, өдөр, цаг	Бомрдуулах бодисын ялгарлын хэмжээ, мг/м3				Хаягдал утаа цэвэрлэх шүүх төхөөрөмж, АҮК	Хаягдал утааны жийн хурд, температур	Хэмжилтийн арга аргачлал, багажны нэр
			SOx	NOx	CO	TPS			
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРОО “ДЦС-3” ТӨХК	ДУНД ДАРАЛТЫН ХЭСГИЙН БК3-75-39 МАЯГИЙН ЗУУХ	2022.01 Сар	990	773	1466		92-95 %	2-3 м/с, 75°c	ТЕСТО-350 XL
		2022.02 Сар	911	750	1328		92-95 %	2-3 м/с, 75°c	ТЕСТО-350 XL
		2022.03 Сар	855	711	1089		92-95 %	2-3 м/с, 75°c	ТЕСТО-350 XL
		2022.04 Сар	870	707	1023		92-95 %	2-3 м/с, 76.5 °c	ТЕСТО-350 XL
		2022.05 Сар	892	720	1057		92-95 %	2-3 м/с, 77.3 °c	ТЕСТО-350 XL
		<b>БҮРЭН ЗОГСОЛТ</b>	Дунд даралтын станц нь 2022.06.01-ний өдрөөс 2022.09.01-ний өдөр хүртэл 3-н сарын хугацаанд бүрэн зогсолт жйдэг болно.						
		2022.09 Сар					92-95 %	2-3 м/с, 82.3 °c	ТЕСТО-350 XL
		2022.10 Сар					92-95 %	2-3 м/с, 82.3 °c	ТЕСТО-350 XL
		2022.11 сар					92-95 %	2-3 м/с, 82.3 °c	ТЕСТО-350 XL
		2022.12 сар					92-95 %	2-3 м/с, 82.3 °c	ТЕСТО-350 XL
	<b>Хэмжилт</b>	<b>Дундаж</b>	<b>903.6</b>	<b>732.2</b>	<b>1192.6</b>				
	<b>MNS:5919:2008</b>	Стандарт	1931	1270	3550	≥1000 mg/m3			

**“ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын станцын яндангаар хаягдах утааны хийн 2022 оны хэмжилт:**

Name:°

**Boiler CEMS Months Data Report**

MNS:5919:2008 standart

Number:°

он	Dust		SO2		Nox		CO	
	Стандарт хэмжих нэгж	хэмжилтийн дүн mg/m3	Стандарт хэмжих нэгж	хэмжилтийн дүн mg/m3	Стандарт хэмжих нэгж	хэмжилтийн дүн mg/m3	Стандарт хэмжих нэгж	хэмжилтийн дүн mg/m3
2022-01	10800 mg/m3	205	1485 mg/m3	706	1100 mg/m3	761	300 mg/m3	195
2022-02		304		707		763		217
2022-03		292		711		764		218
2022-04		328		726		767		221
2022-05		334		738		764		225
2022-06		331		746		765		229
2022-07		334		753		767		230
2022-08		331		755		771		234
2022-09		276		747		765		227
2022-10		216		739		763		223
2022-11								
2022-12								
average		<b>295</b>		<b>733</b>		<b>765</b>		<b>222</b>



Хөндлөнгийн хяналт шалгалт:

Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас хөндлөнгийн хяналт шалгалт удирдамжын дагуу 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр өөрсдийн багажтай ирж станцын үнс баригч төхөөрөмжийн ажиллагаанд хэмжилт хийхэд ашигт үйлийн коэффициент 95 хувьтай гарсан.

/ Жич: Хөндлөнгийн хэмжилтийн дүнг баталгаажуулсан албан бичиг хавсаргав. /

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай:

"ДЦС-3" ТӨХК-нь жилийн нүүрсний хэрэглээнээс хамааруулж шаталтаас ялгаран гарсан бодис тус бүрээр агаар бохирдуулсны төлбөрийг тогтмол төлж байна.

Хүснэгт-1 Агаар бохирдуулсны төлбөр тооцсон мэдээлэл 2021 он


Хаягдлын коэффициент (ХК)							Нүүрсний хэрэглээ	Хаягдлын хэмжээ 2021 онд			
SO <sub>2</sub>	NO <sub>x</sub>	TSP	PM10	PM2.5	CO	SO <sub>2</sub>		NO <sub>x</sub>	TSP	CO	
Нэгж, кг/тн							тн/жил	кг			
ДЦС 3 (Дунд даралтын зуух)	7.35	6.91	10.47	6.81	4.83	1.13	385589	2834079	2664420	4037117	435716
ДЦС 3 (Өндөр даралтын зуух)	1.64	0.88	5.13	3.33	2.37	0.23	1034112	1695944	910019	5304995	237846
							1419701	4530023	3574439	9342111	673561
Засгийн газрын 2011 оны 92 дугаар тогтоолын хавсралт бодис тус бүрийн үнэ											
				1 кг Азот 5 төгрөг / NO <sub>x</sub> /							
				1 кг нүүрстөрөгчийн исэл 1 төгрөг / CO /							
				1 кг хүхрийн давхар исэл 2 төгрөг / SO <sub>2</sub> /							
				1 кг тоосонцор 2 төгрөг / TSP /							
Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдав.							Нийт төлсөн мөнгөн дүн:	<b>46,290,022.5</b>			

Газрын доорх усны хяналтын тухай:

Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар хариуцдаг газрын доорх усны хяналт мониторингийн нэгдсэн сүлжээнд станцын үнс хадгалах сангийн ойролцоо суурилуулсан хяналтын цооногийн мэдээлэлд сар бүр тогтмол хяналт тавин ажиллаж байна.



"ДЦС-3" ТӨХК-ИЙН ҮНС ХАДГАЛАХ САНГИЙН ОЙРОЛЦОО ТАВИГДСАН  
ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХЯНАЛТЫН ЦООНОГУУДЫН БАЙРЛАЛ



Үнс хадгалах сангийн ойролцоо тавьсан хяналтын цооногуудын ерөнхий байрлал

БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Биелэлт
	1	2	3
<b>Агаарын чанар</b>			
1	✓ Тоосжилт (PM <sub>10</sub> , PSM, PM <sub>25</sub> )	Зуухны яндангийн орчим	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний дагуу агаарын чанарын хэмжилтийг цэг тус бүрт хийлгэсэн. Шинжилгээний дүнгүүд хавсаргав.
2	✓ Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ		
3	✓ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин)	Станцын эзэмшил газрын гадны талбайн орчинд	
4		Нүүрс бутлах цехийн орчимд	
5			
6		Үнсэн сангийн орчимд	
7	✓ Бохирдлын цэгэн эх үүсвэр (O <sub>2</sub> , SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)		
8			
9	Үнсэн сан болон зуухны үнс баригч, нүүрснээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэнэ.		Ажиллгаанд байгуу зуух болон үнс хадгалах сангаас улирал бүр үнсний дээж авч МХЕГ-н итгэмжлэгдсэн лабораторт цацрагийн шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүнгүүд хавсаргав.





**Усан орчин**

10	РН, ХХХ, Хатуу бодисын хэмжээ, сульфид	Ашиглаж буй усны эх үүсвэр	Станцын дотоод хяналтын лаборатор сард хоёр удаа , итгэмжлэгдсэн лабораторт сард нэг удаа шаардлагатай тохиолдолд тухай бүрт шинжилгээнд хамруулдаг. Шинжилгээний дүнгүүд хавсаргав.
----	--	----------------------------	--

**Хөрсөн бүрхэвч**

11	Хөрсний химийн болон биологийн, физик шинж чанар, хүнд металлын болон нянгийн бодирдлыг тодорхойлох	Үйл ажиллагаа явуулж буй талбайн орчмын хөрснөөс	Үйл ажиллагаа явуулж буй талбайгаас улирал бүр дээж авч итгэмжлэгдсэн лабораторт хамруулсан. Шинжилгээний дүнгүүд хавсаргав.
12		Үнсэн сангийн орчмоос	
<b>Нийт</b>		<b>3 800.0</b>	

**7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн “Үйл ажиллагааны хүрээ”-нд тусгагдсан төслийн үйл ажиллагаатай холбоотой хуулиудын заалтууд, байгаль орчныг хамгаалах болон бусад стандарт, норм, дүрмийг төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд мөрдөж ажиллах талаар хяналт тавин ажилладаг.

Төслийг аль болох сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн бүлгүүд дэх судалгаа, үнэлгээний дүн болон зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг тулгуур хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, байгаль хамгаалах жил бүрийн ажлыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлдэг.

Нийт ажиллагсадд байгаль хамгаалах талаар хууль тогтоомжийг танилцуулан энэ талын мэдлэг эзэмшүүлэх, амьдрал дээр хэрэгжүүлэх талаар байнга арга хэмжээ авах талаар чиглэл өгөгдсөн.

Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж жил бүрийн бизнес төлөвлөгөөндөө байгаль хамгаалахад зориулсан зардлыг тусган, нарийвчилсан үнэлгээний тайланд төлөвлөж өгсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Биелэлт
	1	2	3
1	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг	ХАБЭА-н зардалд тусгагдсан	1. Станцын цех нэгж бүр Нийслэлийн онцгой байдлын газрын албан хаагчтай улирал бүр танхимын болон практик дадлага сургуулалт хийдэг.



	мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах		
2	Үйл ажиллагааны өвөрмөц түвшин бүрийг нарийвчлан тогтоож, аюулгүйн болон эрүүл мэндийн нөхцөлийн тодорхойлолт, эрсдэлийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийх, хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан зохион байгуулах.	ХАБЭА-н зардалд тусгагдсан	2. Ажлын байр тус бүрээр дотоод хяналтын хэлтэс, захиргаан хүний нөөцийн алба, ажлын байр хариуцсан цехүүд хамтран ажлын байрны эрсдэлийн үнэлгээг сар бүр хийж эрсдэлийг бууруулан ажилладаг.
3	Станцын ажлын байруудад яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлээр хангах.	ХАБЭА-н зардалд тусгагдсан	3. Станцын шуурхай ажиллагааны бүх ажлын байруудад анхан шатны тусламжийн эм багаж хэрэгслээр хангасан. Мөн өдрийн цагаар эмнэлэг ажиллаж шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байна.
4	Станцын жилийн үйл ажиллагаанаас агаар мандалд хаягдсан бодисуудын төлбөрийг хуулийн хугацаанд төлөх.	Компаний бизнес төлөвлөгөөнд тусгагдсан / 45 сая.төгрөг /	4. Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар 46 сая төгрөгийн төлбөр төлсөн.
5	Компанийн үйл ажиллагаанд байгаль орчны мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар аудит хийлгэнэ	Ажлын даалгавар боловсруулж тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгоно.	5. БОАЖЯ-аас олгосон аудит хийх тусгай зөвшөөрөлтэй "БОАД" ХХК-иар байгаль орчны аудит хийлгэсэн. Ерөнхий дүгнэлт хавсаргав.
	Нийлбэр		

## 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-ний заалт бүрээр гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл оруулав:

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	БИЕЛЭЛТ
	1	2	3	4	5
1	Нийслэлийн байгаль орчны газар	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг дүгнүүлэх	Тухайн ашиглалтын жилд хэрэгжүүлсэн байгаль орчны арга хэмжээ,	11 сарын 1-ний дотор	Тайлант хугацаанд жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл гаргаж хүргүүлсэн.
2	Хан-Уул дүүргийн 3-р хорооны засаг дарга	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг танилцуулах	дараагийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Хагас жил тутамд	ХУД-н 3-р хорооны засаг даргатай уулзалт хийж иргэдэд мэдээлэл хүргүүлсэн.
3	Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэдийн хурал	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг танилцуулах		Хагас жил тутамд	
	Нийт				



## ДУГНЭЛТ

Манай компани нь Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн цахилгаан хэрэглээний 16 %, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 31.%, үйлдвэрлэлийн уурын хэрэглээний 48 %-ийг хангадаг Улсын онц чухал объект юм.

Эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний гол онцлог нь үйлдвэрлэл, дамжуулалт, хэрэглээ нь нэгэн зэрэг явагддаг тул үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон хоногоор хадгалах боломжгүй мөн үйлдвэрлэл явуулж байгаа тоног төхөөрөмжийн хувьд богино хугацаанд ажилд залгаж, зогсоож болдоггүй онцлогтой үйлдвэр юм.

Манай компанийн зүгээс дулаан цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны тэнцэлтэй уялдуулж байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, ажиллагсадын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг хангах ажлыг өөрсдийн санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлэн ажилладаг.

Энэ жилийн хугацаанд манай улсад цар тахалын нөхцөл байдал өмнөх жилүүдийг бодвол харьцангуй дээрдсэн боловч БНХАУ-ын хилийн боомтоор бараа материал нэвтрүүлэх хугацаа удааширсан мөн ОХУ, Украин улсуудын хооронд үүссэн дайны нөхцөл байдлаас шалтгаалж үйлдвэрлэл явуулахад шаардлагатай сэлбэг, бараа материал цаг хугацаандаа орж ирэхгүй байх, импортын бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаасан эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хувьд БОАЖЯ-аар батлуулан гүйцэтгэлийг ханган ажиллаа. Манай станцын хувьд хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, стандарт хэмжээг мөрдүүлэхэд дараах томоохон ажлуудыг хийлээ.

Үүнд: Дунд даралтын станцыг бүрэн шинэчлэх төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авч гэрээ байгуулах бэлтгэл ажил хангав. Тунгаах сангийн усыг цэвэршүүлэх зориулалттай тоног төхөөрөмжүүдийг суурилуулж туршилт тохируулгын ажил хийн дүгнэлт гаргуулахаар МУ-ын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-т хандахад Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал усны стандартыг хангаж байна гэсэн дүгнэлт гарч Туул голын сав газрын захиргаатай хаягдал ус нийлүүлэх гэрээ байгуулсан. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт мод тарих, Туул гол цэвэрлэх аянд оролцож Яармагийн гүүрнээс Сонсголонгийн гүүр хүртэлх талбайд их цэвэрлэгээ хийж хүлээлгэн өгсөн. Компанийн ээлжийн ажилтнуудад байгаль



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ТБХ-09-2015



орчны талаарх мэдээлэл мэдлэг, олгох зорилгоор мэргэжлийн байгууллалатай хамтарч сургалт зохион байгуулах, ажлуудыг хэрэгжүүлсэн. Хүрээлэн буй орчны хяналт шинжилгээг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториудад улирал бүр хийлгэж холбогдох хяналтын байгууллагуудыг мэдээллээр ханган шаардлагатай тусгай зөвшөөрөл, гэрээг сунгуулан холбогдох төлбөрүүдийг хуулийн хугацаанд төлж ажиллаа.

Станцын үйл ажиллагаанд байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагуудын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд шаардлагатай баримт материалыг шуурхай гарган өгч нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулах зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүрт нь авч ажилласан.

Цаашид станцын тоног төхөөрөмж, шугам хоолой, барилга байгууламжийн хамгаалалтын бүст газар олголт хийгдэж байгаа нь бидний ажилд нилээд хүндрэл учруулж байна.

Дүгнэлт бичсэн:  
“ДЦС-3” ТӨХК-ийн Үйлдвэрлэлийн  
экологийн инженер

Э.Энхбат



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УСНЫ ГАЗАР**

16050 Улаанбаатар хот, Байнгол дүүрэг, 2 дугаар хороо.

Чингүнжавын гудамж. Утас/Факс: (976-51) 26 55 76.

И-мэйл: contact@mwa.mn

2022.02.18 № 05/140


Танай 2022.01.28 ны № 1/136 -г

**“ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК,  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА,  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ**

Танай байгууллагын 2022 оны 1/136 албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг судалж үзээд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

УС АШИГЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ШҮРЭНЦЭЦЭГ

16322033

2022 onii alban bichig

## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2022 оны 02 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар-09

Улаанбаатар  
хот

**1. Аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар -**

"Дулааны III цахилгаан станц" ТӨХК, гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ДЦС-III ТӨХК байр, утас: 343024, 341901. Улсын бүртгэлийн дугаар: 9012001004, регистрийн дугаар: 2546191.

**2. Төслийн нэр, байршил -**

"Дулааны цахилгаан станц III" ТӨХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутагт байрлана. Туул голын сав газарт хамаарагдана.

**3. Төсөл хэрэгжүүлэгч -**

"Дулааны III цахилгаан станц" ТӨХК

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат IX, УI -**

- 14/2006 дугаартай цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл (төвийн бүсийн нэгдсэн сүлжээ)

- 15/2006 дугаартай дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл (Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем)

- 28/2004 дугаартай дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх)

- 26/2004 дугаартай цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид)

- 14/2015 дугаартай цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид)

- 27/2004 дугаартай дулаан түгээх тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид).

Улсын тусгай объектод хамаарах бөгөөд 88.5га газар эзэмшдэг. 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 000438716 дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээтэй.

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт -**

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах.

**6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/ -**


Өндөр даралтын станц нь БЗК-220-100 маркийн 7ш уурын генератор, ПТ-25-90-10М маркийн 4 турбин, дунд даралтын станц нь БКЗ-75-39 маркийн 6 уурын генератор, ПТ-12-35/10М маркийн 4 турбинтай. 2014 онд ТГ-9, С-50/8,8 параметртэй 50мВт-ын өргөтгөл хийгдсэн. Ус хөргөх цамхаг, хими цех, нүүрсний агуулахтай. Станц 994 ажилчидтай хоногт 4 ээлжээр, 365 хоног тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг. Нийт суурилагдах хүчин чадал 198мВт.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ -**

2022 онд 1,053,616.0 мВтцаг цахилгаан, эрчим хүч, 2,274,588.0 Гкал дулааны эрчим хүч, 258,000.0 Гкал уур үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/ -**

Унд ахуйн хэрэглээний усыг нийслэлийн ус хангамжийн төвлөрсөн сүлжээнээс, техникийн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн 18 худгаас ус авч ашигладаг.



**9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/ -**

Техникийн ус нөөцлөх 1,000.0м<sup>3</sup> багтаамжтай 1ш бак, 846,000.0м<sup>3</sup> багтаамжтай үнсэн сан-1ш, 124,000.0м<sup>3</sup> багтаамжтай тунгагдсан ус нөөцлөх сан-1ш, галын аюулгүй байдлыг хангах 250.0м<sup>3</sup> багтаамжтай 2 ширхэг сантай. 57,600.0м<sup>3</sup> багтаамжтай үнсэн сан-1ш шинээр баригдсан.

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/ -**

Сонсголонгийн гүүрний баруун талд байрлах техникийн усны эх үүсвэрийн нийт 18 худагтай бөгөөд үүнээс 4 нь засвартай ашиглалтаас хасагдсан.

Нэгдсэн шугам дээр UFM 005 маркийн усны тоолууртай, дулааны шугам сүлжээ, техникийн уурын шугам нэмэлт ус өгөх хоолойг тоолууржуулсан байна.

Худгийн дугаар	Уртраг	Өргөрөг	Гүн,м	Ундарга л/с	Насосны марк
№1	47°53'48"	106°47'45"	35.0	60.0	SP160-4-AA
№2	47°53'53.5"	106°47'32"	40.0	60.2	SP160-4-AA
№3	47°53'57.8"	106°47'19.1"	50.0	70.0	SP160-4-AA
№4	47°54'02"	106°47'04.5"	50.0	72.3	ЭЦВ-12-160-65
№5	47°54'05.5"	106°46'46.5"	41.0		Ашиглахгүй байгаа
№6	47°54'08.43"	106°46'46.6"	38.0		Ашиглахгүй байгаа
№7	47°54'11"	106°46'25"	42.0	55.6	ЭЦВ-12-120-60
№8	47°54'10.37"	106°46'09.17"	38.5	63.0	SP160-4-AA
№9	47°53'48"	106°45'45"	38.5	53.0	SP160-4-AA
№10	47°54'00"	106°47'58.6"	50.0		SP160-4-AA
№11	47°54'02.28"	106°45'32"	50.0	60.2	SP160-4-AA
№12	47°54'03.3"	106°45'18.18"	50.0	69.0	SP160-4-AA
№13	47°54'02.56"	106°45'02.8"	50.0		Ашиглахгүй байгаа
№14	47°54'01.52"	106°44'39.1"	39.0	51.6	ЭЦВ-12-160-65
№15	47°53'59.7"	106°44'15.24"	44.0	79.0	Ашиглахгүй байгаа
№16	47°54'20.41"	106°44'06"	44.0	69.0	SP160-4-AA
№17	47°54'12.86"	106°43'54.08"	47.0	47.0	SP160-4-AA
№18	47°54'13.3"	106°43'36.6"	40.0	77.0	SP160-4-AA

**11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/ -**

Худгийн усыг өргөлтийн станцад 2x1,000.0м<sup>3</sup> санд хуримтлуулан өргөлтийн 1-р насосны тусламжтай 500.0мм-ийн голчтой 6.0км урт хос хоолойгоор дамжуулан станцын технологийн хэрэгцээнд ашигладаг.

**12. Хэрэглэгчээс гарах хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин -**

Ахуйн бохир усыг Улаанбаатар хотын ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг.

Үйлдвэрийн хаягдал усыг үнс зайлуулах сүлжээнд ашиглаж, үнсэн санд тунгаан эргүүлэн ашигладаг. Станцын үнсийг усаар зайлуулж, дахин ашиглаж байгаа усыг зуухны үнс шаарга зайлуулах систем буюу скруббер-трубовентурд ашиглан дахин үнсэн санд хаяж тунгаагаад буцаан хэрэглэх гэсэн битүү цикл системээр ашигладаг.

**13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл -**

"Үйл ажиллагааны болон шинээр баригдах үнсэн сан" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2019 онд "Экологийн бүтээмж" ХХК хийж гүйцэтгэсэн.

**14. Онцгой нөхцөл -**

- Усны тухай хуулийн 24.3-т заасны дагуу бохир ус алдагдахаас сэргийлж, усны алдагдлыг бууруулан ажиллах, хаягдлын сангийн усны алдагдлыг хянах, мөн усны эх үүсвэрийг хянах зорилгоор усны хяналт-шинжилгээний ажлыг тогтмол хийх.

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн



сарын 15-ны дотор Усны газарт ирүүлж, Усны тухай хуулийн 25.2-т зааснаар хаягдал усны дүгнэлт гаргуулах.

**15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох -**

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу станцын техник, технологийн усны хэрэглээг тооцоход:

$1,053,616.0 \text{ мВтц} \times 0.42 \text{ м}^3/\text{мВтц} = 442,518.72 \text{ м}^3$  – цахилгаан үйлдвэрлэхэд зарцуулах ус  
 $2,274,588.0 \text{ Гкал} \times 3.93 \text{ м}^3/\text{Гкал} = 8,939,130.84 \text{ м}^3$  – дулаан үйлдвэрлэхэд зарцуулах ус  
 $258,000.0 \text{ Гкал} \times 2 \text{ тн}/\text{Гкал} \times 1 \text{ м}^3/\text{тн} = 516,000.0 \text{ м}^3$  – уур үйлдвэрлэхэд зарцуулах ус

**Нийт:**  $442,518.72 \text{ м}^3 + 8,939,130.84 \text{ м}^3 + 516,000.0 \text{ м}^3 = 9,897,649.56 \text{ м}^3$  ус шаардлагатай.

$994 \text{ хүн} \times 150 \text{ л}/\text{хон} \times 365 \text{ хон} = 54,421.5 \text{ м}^3$  - унд-ахуйн усны нийт хэрэгцээ

ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны ус ашиглалтын төлөвлөгөө:

Эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай **9,897,649.56 м<sup>3</sup>** усны **1,600,000.0 м<sup>3</sup>** усыг эргэлтийн усаар хангаж, станцын усан хангамжийн эх үүсвэрээс **8,297,649.56 м<sup>3</sup>** усыг шууд болон нөхөн сэлбэлтээр авч ашиглахаар тооцож тусгасан байна.

**16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ -**

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу хүн амын унд-ахуйд хэрэглэх **54,421.5 м<sup>3</sup>** усны төлбөрийг ус ашигласны төлбөрөөс чөлөөлнө.

Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ус хангамжийн эх үүсвэрээс шууд болон нөхөн сэлбэлтээр авч ашиглах **8,297,649.56 м<sup>3</sup>** газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон усны экологи-эдийн засгийн суурь үнэ, 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, 2013 оны 326 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашигласны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 9,440.0 \text{ төг}/\text{м}^3 \times 0.15 \times 0.05 = 70.8 \text{ төг}$

$9,440.0 \text{ төг}/\text{м}^3$  – Туул голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 8-д заасан хувь, хэмжээ

0.05 – Эрчим хүчний зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$8,297,649.56 \text{ м}^3 \times 70.8 \text{ төг}/\text{м}^3 = 587,473,589.0 \text{ төг}$

/Таван зуун наян долоон сая дөрвөн зуун далан гурван мянга таван зуун наян есөн төгрөг/

**17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар -**

- Усны тухай хуулийн 24.3-т заасны дагуу ослын улмаас хаягдал усыг цэвэрлэхгүйгээр хаях болсон тохиолдолд Сав газрын захиргаа, зохих шатны Засаг даргад цаг алдалгүй мэдэгдэж, усны бохирдлыг бууруулах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэхийг анхаарах.


**18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж -**

- Усны тухай хуулийн 28.6, 29.1 дэх заалтуудыг үндэслэн Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх;





- Усны тухай хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 24.3-т заасны дагуу үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед сав газрын захиргаа болон төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан (усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн тухай акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор "Усны газар"-т [office@water.gov.mn](mailto:office@water.gov.mn) цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлэх;



УС АШИГЛАЛТЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

*Х.Мягмаржав* Х.МЯГМАРЖАВ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**УСНЫ ГАЗАР**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингүнжавын гудамж. Утас/Факс: (976-51) 26 55 78,  
И-мэйл: contact@mwa.mn

2022.09.20 № 06/1069  
танай 2022.09.09 -ны № 1/1464 -т

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН  
СТАНЦ” ТӨХК-Д

*С.Т.Т.Т., Т.В.Т.Т.*

*Уулам,  
Таммицүлэв.*


**Хаягдал усны дүгнэлт хүргүүлэх тухай**

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал”, БОАЖ-ын Сайд, БХБ-ын Сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”, танай компанийн 2022 оны 1/1464 тоот хаягдал усны дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг тус тус үндэслэн 2021 оны хаягдал усны дүгнэлтийг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийг тооцон хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Туул голын сав газрын захиргаа, Том Татвар төлөгчийн газарт.

Хавсралт *6*... хуудастай.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БАТЗАЯА

162220827

## ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2022 оны 09 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар-92

Улаанбаатар хот  
Утас:265528, 265578

### Нэг. Ерөнхий мэдээлэл

#### 1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, утас: 976-11343024, 99001531, Улсын бүртгэлийн дугаар: 9012001004, Регистрийн дугаар: 2546191

#### 1.2. Төслийн нэр, байршил

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэх станц нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө дагуу байрладаг. Туул голын сав газарт хамаарч байна.

### Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

#### 2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин:

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК нь унд ахуйн хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын төвийн Ф1400 мм-ийн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг бөгөөд технологийн хаягдал усыг 785'000 м<sup>3</sup> эзлэхүүнтэй үнсэн сан, 57'600 м<sup>3</sup> эзлэхүүнтэй тунгаах санд механик аргаар цэвэрлэн, эргүүлэн ашигладаг байна. Мөн үнсэн сангийн ашиглалтын хугацааг уртасгах зайлшгүй шаардлагын дагуу 2022 онд 150 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай гүн цэвэрлэгээний "Ус цэвэршүүлэх байгууламж" шинээр барьж ашиглалтад оруулсан байна.

#### 2.2. Хаягдал усны хэмжээ:

Бохир усны тоолуур суурилуулаагүй тул технологийн хаягдал усны хэмжээг БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь заалтад заасны дагуу цэвэр усны шугам дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн ус буюу сүлжээний нэмэлт ус, дотоод циклийн алдагдал, үйлдвэрийн ууранд зарцуулсан усны эзлэхүүнийг хасаж тооцов. Унд ахуйн хаягдал усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 74 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн харилцааны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэгдэж байгаа бохир усны хэмжээг тооцохдоо цэвэр усны хэрэглээг үндэслэнэ" гэж заасны дагуу "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын борлуулалтын орлогын бичилтийг үндэслэн тооцов.

Тооцооны хамрах хугацаа	Технологид нөхөн сэлбэлтээр авсан ус, м <sup>3</sup> /улирал	Технологид тунгаах сангаас эргүүлэн авсан ус, м <sup>3</sup> /улирал	Унд ахуйн хаягдал ус, м <sup>3</sup> /жил
2021 оны I улирал	1307000	252700	107443
2021 оны II улирал	847100	249700	
2021 оны III улирал	869000	370800	
2021 оны IV улирал	879300	768400	

#### 2.3. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн унд ахуйн хаягдал усанд сорьцын шинжилгээ хийлгээгүй тул БОАЖ-ын Сайд, БХБ-ын Сайдын хамтарсан 2019 оны А-816/218 тоот тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн Органик бодис /химийн хэрэгцээт хүчилтөрөгч/-ын хэмжээг бусад үйлчилгээ 0.8 кг/м<sup>3</sup>-ээр тооцоолсон болно. Үнсэн санд нийлүүлж буй технологийн хаягдал усанд Байгаль орчин, хэмжилзүйн төв лаборатори, Ханлаб ХХК-ийн лабораторид хийлгэсэн шинжилгээний дүнг хянаж үзэхэд:

Бохирдуулах бодисын төрөл (i)	улиралд хийсэн шинжилгээний давтамж	ЗДХ, (мг/л)	Сi - хаягдал усны холимог дээжин дэх i бохирдуулах бодисын дундаж агууламж, (мг/л)			
			I улирал	II улирал	III улирал	IV улирал
Жинлэгдэх бодис	1/1/1/1	30	4.00	1.20	4.60	40.80
Органик бодис /XXX/	1/0/1/1	50	20.00		83.20	4.80
Органик бодис /БХХ/	1/0/1/1	20	3.00		6.80	1.40
Органик бодис /ПИЧ/	1/1/0/0	20	2.56	1.30		
Органик бодис /нийт азот/	1/1/1/1	15	1.18	1.46	0.66	5.62
Эрдэс бодис /фосфор/	1/1/1/1	1.5	0.01	0.01	0.64	0.01
Хүнд металл /бор/	1/0/0/0	0.5	0.49			
Хүнд металл /барий/	1/0/0/0	1.5	0.37			
Хүнд металл /кобальт/	1/0/0/0	0.02	0.00			
Хүнд металл /хром/	1/0/0/0	0.3	0.03			
Хүнд металл /төмөр/	1/0/0/0	1	0.34			
Хүнд металл /манган/	1/0/0/0	0.5	0.18			
Хүнд металл /молибден/	1/0/0/0	0.5	0.10			
Хүнд металл /никель/	1/0/0/0	0.2	0.01			
Хүнд металл /стронций/	1/0/0/0	2	1.48			
Хүнд металл /ванадий/	1/0/0/0	0.1	0.03			

### Гурав. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

3.1. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ыг тус тус үндэслэн тооцоход:

№	Хамрагдах хугацаа	Хаягдал усны хэмжээ, м <sup>3</sup>	Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр
Унд ахуйн хаягдал ус					
1	2021 он /Унд ахуй/	107,443	4,297,720.00		4,297,720.00
Технологид нөхөн сэлбэлтээр авч ашигласан хаягдал ус					
1	2021 оны I улирал	1,307,000	3,984,164.70		3,984,164.70

2	2021 оны II улирал	847,100	167,929.10		167,929.10
3	2021 оны III улирал	869,000	4,150,109.37	3,615,040.00	7,765,149.37
4	2021 оны IV улирал	879,300	2,313,596.57	1,793,772.00	4,107,368.57
Технологид тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан хаягдал ус					
1	2021 оны I улирал	252,700	771,575.99	-	770,312.49
2	2021 оны II улирал	249,700	49,500.53	-	49,500.53
3	2021 оны III улирал	370,800	1,770,840.68	1,542,528.00	3,313,368.68
4	2021 оны IV улирал	768,400	2,021,798.71	1,567,536.00	3,589,334.71
Нийт төлбөр, төгрөгөөр		5,651,443	19,533,770.65	8,518,876.00	28,044,848.15

**3.2.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу эргүүлэн ашигласан 1,641,600 м<sup>3</sup> хаягдал усны төлбөр болох 7,722,516.41 төгрөгийг 100% чөлөөлөхөд **20,322,331.74** /хорин сая гурван зуун хорин хоёр мянга гурван зуун гучин нэгэн төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөг ногдож байна.

#### **Дөрөв. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ**

- 4.1.** Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Туул голын сав газрын захиргаатай байгуулсан "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ"-г сунгуулах;
- 4.2.** Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны Туул голын сав газрын захиргаагаар "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг"-ийг сунгуулах;
- 4.3.** Усны тухай хуулийн 16<sup>1</sup> дугаар зүйлийн 16<sup>1</sup>.4.8 дахь заалтын дагуу тус Газрын Усны хяналт шинжилгээний хэлтсээс шинээр суурилуулсан ус цэвэршүүлэх байгууламжийн технологи, үйл ажиллагаатай танилцаж, цэвэрлэгдээд гарч буй усанд хийсэн лабораторийн шинжилгээний дүнд хяналт тавихад "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг хангаж байна. Иймд Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтад заасны дагуу Туул голын сав газрын захиргаагаар хаягдал ус зайлуулах цэгийг тогтоолгох;
- 4.4.** БОНХ-ийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;
- 4.5.** "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг бэлгальд нийлүүлэх, стандартаас давсан бол Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;
- 4.6.** Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, илгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;
- 4.7.** БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал"-ын хүснэгт №22-т заасан

хаягдал усанд тодорхойлох үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй тохиолдолд бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр авч тооцохыг анхаарах;

4.8. Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;


4.9. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Усны газрын [office@water.gov.mn](mailto:office@water.gov.mn) цахим хаягаар 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХЗУЛ

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Л.ХИШИГДУЛАМ

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТЭХК-ийн ус бохирдуулсны төлбөрийн тооцоо**

№	Бохирдуулах бодисын төрөл	Шинжилгээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь бохирдуулах бодисын дундаж агууламж		ЗДХ-ээс хэтрэсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шатлан өсгөх хэлбэр	Хаягдал усны хэмжээ, м <sup>3</sup>	Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ			Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр
				мг/л	кг/м <sup>3</sup>					хэмж	их нэгж	тариф			
1	Органик бодис /XXX/	0	50	800	0.800	0.00	0	107,443	85,954.40	төгр/кг	50	4,297,720.00		4,297,720.00	
2021 оны I үнд ахуйн хаягдал усны төлбөр, төгрөгөөр															
1	Жинлэгдэх бодис	1	30	4.00	0.0040	0.13	0	1,307,000	5228.00	төгр/кг	50	261,400.00		261,400.00	
2	Органик бодис /XXX/	1	50	20.00	0.0200	0.40	0	1,307,000	26140.00	төгр/кг	50	1,307,000.00		1,307,000.00	
3	Органик бодис /БХХ/	1	20	3.00	0.0030	0.15	0	1,307,000	3921.00	төгр/кг	50	196,050.00		196,050.00	
4	Органик бодис /ПИЧ/	1	20	2.56	0.0026	0.13	0	1,307,000	3345.92	төгр/кг	50	167,296.00		167,296.00	
5	Органик бодис /нийт азот/	1	15	1.18	0.0012	0.08	0	1,307,000	1545.61	төгр/кг	50	77,280.30		77,280.30	
6	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	1,307,000	13.07	төгр/кг	20	261.40		261.40	
7	Бор	1	0.5	0.49	0.0005	0.98	0	1,307,000	640.43	төгр/кг	500	320,215.00		320,215.00	
8	Барий	1	1.5	0.37	0.0004	0.25	0	1,307,000	483.59	төгр/кг	500	241,795.00		241,795.00	
9	Кобальт	1	0.02	0.00	0.0000	0.10	0	1,307,000	2.61	төгр/кг	500	1,307.00		1,307.00	
10	Нийт хром	1	0.3	0.03	0.0000	0.10	0	1,307,000	39.21	төгр/кг	500	19,605.00		19,605.00	
11	Нийт төмөр	1	1	0.34	0.0003	0.34	0	1,307,000	444.38	төгр/кг	500	222,190.00		222,190.00	
12	Манган	1	0.5	0.18	0.0002	0.36	0	1,307,000	235.26	төгр/кг	500	117,630.00		117,630.00	
13	Молибден	1	0.5	0.10	0.0001	0.20	0	1,307,000	130.70	төгр/кг	500	65,350.00		65,350.00	
14	Никель	1	0.2	0.01	0.0000	0.05	0	1,307,000	13.07	төгр/кг	500	6,535.00		6,535.00	
15	Стронций	1	2	1.48	0.0015	0.74	0	1,307,000	1934.36	төгр/кг	500	967,180.00		967,180.00	
16	Ванадий	1	0.1	0.03	0.0000	0.30	0	1,307,000	39.21	төгр/кг	500	19,605.00		19,605.00	
2021 оны I улиралд нөхөн сэлбэлтээр авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр															
1	Жинлэгдэх бодис	1	30	1.20	0.0012	0.04	0	847,100	1,016.52	төгр/кг	50	50,826.00		50,826.00	
2	Органик бодис /ПИЧ/	1	20	1.30	0.0013	0.07	0	847,100	1,101.23	төгр/кг	50	55,061.50		55,061.50	
3	Органик бодис /нийт азот/	1	15	1.46	0.0015	0.10	0	847,100	1,236.77	төгр/кг	50	61,838.30		61,838.30	
4	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	847,100	10.17	төгр/кг	20	203.30		203.30	
2021 оны II улиралд нөхөн сэлбэлтээр авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр															
1	Жинлэгдэх бодис	1	30	4.60	0.0046	0.15	0	869,000	3,997.40	төгр/кг	50	199,870.00		199,870.00	
2	Органик бодис /XXX/	1	50	83.20	0.0832	1.66	2	869,000	72,300.80	төгр/кг	50	3,615,040.00	3,615,040.00	7,230,080.00	
3	Органик бодис /БХХ/	1	20	6.80	0.0068	0.34	0	869,000	5,909.20	төгр/кг	50	295,460.00		295,460.00	
4	Органик бодис /нийт азот/	1	15	0.66	0.0007	0.04	0	869,000	570.93	төгр/кг	50	28,546.65		28,546.65	
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.64	0.0006	0.43	0	869,000	559.64	төгр/кг	20	11,192.72		11,192.72	
2021 оны III улиралд нөхөн сэлбэлтээр авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр															
1	Жинлэгдэх бодис	1	30	40.80	0.0408	1.36	2	879,300	35,875.44	төгр/кг	50	1,793,772.00	3,615,040.00	7,765,149.37	
2	Органик бодис /XXX/	1	50	4.80	0.0048	0.10	0	879,300	4,220.64	төгр/кг	50	211,032.00	1,793,772.00	3,587,544.00	
3	Органик бодис /БХХ/	1	20	1.40	0.0014	0.07	0	879,300	1,231.02	төгр/кг	50	61,551.00		61,551.00	
4	Органик бодис /нийт азот/	1	15	5.62	0.0056	0.37	0	879,300	4,941.67	төгр/кг	50	247,083.30		247,083.30	
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	879,300	7.91	төгр/кг	20	158.27		158.27	
2021 оны IV улиралд нөхөн сэлбэлтээр авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр															
										2,313,596.57		1,793,772.00	5,408,812.00	4,107,368.57	
										14,920,054.74		14,920,054.74	20,322,331.74	20,322,331.74	

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан хаягдал усны төлбөрийн тооцоо**

№	Божирдуулах бодисын төрөл	Шинжилгээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь божирдуулах бодисын дундаж агууламж		ЗДХ-ээс хэтэрсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шатлан өсгөх хэлбэр	Хаягдал усны хэмжээ, м <sup>3</sup>	Хаягдал усан дахь божирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ			Ус божирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр	
				мг/л	кг/м <sup>3</sup>					хэмж	их нэгж	тариф				
1	Жинлэгдэх бодис	1	30	4.00	0.0040	0.13	0	252,700	1010.80	төгр/кг	50	50,540.00		50,540.00		
2	Органик бодис /XXX/	1	50	20.00	0.0200	0.40	0	252,700	5054.00	төгр/кг	50	252,700.00		252,700.00		
3	Органик бодис /БХХ/	1	20	3.00	0.0030	0.15	0	252,700	758.10	төгр/кг	50	37,905.00		37,905.00		
4	Органик бодис /ЛИЧ/	1	20	2.56	0.0026	0.13	0	252,700	646.91	төгр/кг	50	32,345.60		32,345.60		
5	Органик бодис /нийт азот/	1	15	1.18	0.0012	0.08	0	252,700	298.83	төгр/кг	50	14,941.65		14,941.65		
6	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	252,700	2.53	төгр/кг	20	50.54		50.54		
7	Бор	1	0.5	0.49	0.0005	0.98	0	252,700	123.82	төгр/кг	500	61,911.50		61,911.50		
8	Барий	1	1.5	0.37	0.0004	0.25	0	252,700	93.50	төгр/кг	500	46,749.50		46,749.50		
9	Кобальт	1	0.02	0.00	0.0000	0.10	0	252,700	0.51	төгр/кг	500	252.70		252.70		
10	Нийт хром	1	0.3	0.03	0.0000	0.10	0	252,700	7.58	төгр/кг	500	3,790.50		3,790.50		
11	Нийт төмөр	1	1	0.34	0.0003	0.34	0	252,700	85.92	төгр/кг	500	42,959.00		42,959.00		
12	Манган	1	0.5	0.18	0.0002	0.36	0	252,700	45.49	төгр/кг	500	22,743.00		22,743.00		
13	Молибден	1	0.5	0.10	0.0001	0.20	0	252,700	25.27	төгр/кг	500	12,635.00		12,635.00		
14	Никель	1	0.2	0.01	0.0000	0.05	0	252,700	2.53	төгр/кг	500	1,263.50		-		
15	Стронций	1	2	1.48	0.0015	0.74	0	252,700	374.00	төгр/кг	500	186,998.00		186,998.00		
16	Ванадий	1	0.1	0.03	0.0000	0.30	0	252,700	7.58	төгр/кг	500	3,790.50		3,790.50		
2021 оны I улиралд тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр																
1	Жинлэгдэх бодис	1	30	1.20	0.0012	0.04	0	249,700	299.64	төгр/кг	50	771,575.99		770,312.49		
2	Органик бодис /ЛИЧ/	1	20	1.30	0.0013	0.07	0	249,700	324.61	төгр/кг	50	14,982.00		14,982.00		
3	Органик бодис /нийт	1	15	1.46	0.0015	0.10	0	249,700	364.56	төгр/кг	50	16,230.50		16,230.50		
4	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	249,700	3.00	төгр/кг	20	18,228.10		18,228.10		
2021 оны II улиралд тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр																
1	Жинлэгдэх бодис	1	30	4.60	0.0046	0.15	0	370,800	1,705.68	төгр/кг	50	49,500.53		49,500.53		
2	Органик бодис /XXX/	1	50	83.20	0.0832	1.66	2	370,800	30,850.56	төгр/кг	50	85,284.00		85,284.00		
3	Органик бодис /БХХ/	1	20	6.80	0.0068	0.34	0	370,800	2,521.44	төгр/кг	50	1,542,528.00	1,542,528.00	3,085,056.00		
4	Органик бодис /нийт азот/	1	15	0.66	0.0007	0.04	0	370,800	243.62	төгр/кг	50	126,072.00		126,072.00		
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.64	0.0006	0.43	0	370,800	238.80	төгр/кг	20	12,180.78		12,180.78		
2021 оны III улиралд тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр																
1	Жинлэгдэх бодис	1	30	40.80	0.0408	1.36	2	768,400	31,350.72	төгр/кг	50	4,775.90	1,770,840.68	1,542,528.00	4,775.90	
2	Органик бодис /XXX/	1	50	4.80	0.0048	0.10	0	768,400	3,688.32	төгр/кг	50	1,567,536.00	1,567,536.00	3,313,368.68		
3	Органик бодис /БХХ/	1	20	1.40	0.0014	0.07	0	768,400	1,075.76	төгр/кг	50	184,416.00		184,416.00		
4	Органик бодис /нийт азот/	1	15	5.62	0.0056	0.37	0	768,400	4,318.41	төгр/кг	50	53,788.00		53,788.00		
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	0.01	0.0000	0.01	0	768,400	6.92	төгр/кг	20	215,920.40		215,920.40		
2021 оны IV улиралд тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр																
													2,021,798.71	1,567,536.00	138.31	3,589,334.71
													<b>4,613,715.91</b>	<b>3,110,064.00</b>	<b>138.31</b>	<b>7,722,516.41</b>

2021 оны тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан усны төлбөр, төгрөгөөр



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

## ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 21/10

..... **УСНЫ ГАЗАР** ..... -ын гаргасан  
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

20<sup>21</sup> оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах ....38.. тоот

дүгнэлтийг үндэслэн **Улаанбаатар** аймаг/нийслэл ..... **Хан-Уул**.....

сум/дүүргийн **3 дугаар хороонд** ..... байршилтай  
/ хаяг /

**Эрчим хүчний үйлдвэрлэлийн**  
/ Үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа **ДУЛААНЫ 3-Р ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХЖ-Д**  
/ хүн, хуулийн этгээдийн нэр /

**Улаанбаатар** аймаг/нийслэл, ..... **Хан-Уул**..... сум/дүүргийн

**3-Р ХОРОО, ТУУЛ ГОЛЫН ЭРГИЙН ДАГУУ** ..... байршилтай хаягдал

ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны  
шугамд жилд **208.8** мян.м<sup>3</sup> хаягдал усыг “Хүрээлэн байгаа

орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”,

“Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд  
нийлүүдэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар

тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг

/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон  
дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.

Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны  
шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

ТУУЛ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

/ Зөвшөөрөл олгосон байгууллага /

Тамга

Зөвшөөрлийн бичиг олгогч:


/ Гарын үсэг /

/ **Б.ОЮУНБОЛД**..... /

/ Гарын үсгийн тайлал /

20<sup>21</sup> оны 03 -р сарын 25 -ны өдөр

СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Огноо	Гарын үсэг / тамга
<p>Усны газрын 2022 оны 92 дугаартай хаягдал усны дүгнэлтийн дагуу 1 жилээр сунгав. Хэмжээ: 3'903.0 мян.м<sup>3</sup>/жил</p>	<p>2022.09.29</p>	<p>Туул голын сав газрын захиргааны дарга</p>  <p>Д.НЯМДОРЖ</p> <p>6030548 УХА00053</p>

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,  
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,  
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

**ЗӨВШӨӨРӨЛ**

Огноо: 2022-05-25

Дугаар: 0002198

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9012001004

Регистрийн дугаар: 2546191

Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, 0

Утас: 343024, 341901

Дараах химийн хортой, аюултай бодис:

Ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2022.05.25-2025.12.31

хүртгэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 10 нэр төрөл бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: ---

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
Төрийн нарийн бичгийн дарга


Э. БАТЛУГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц. БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг  
Ашиглах 0002198 дугаартай  
тусгай зөвшөөрлийн хавсралт**

Д/д	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, тн
1	Аммиак усан уусмал	Ammonium hydroxide	NH <sub>4</sub> OH	7664-41-7	22.8
2	Идэмхий шүлт	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	60
3	Тринатри фосфат	Trisodium phosphate	Na <sub>3</sub> PO <sub>4</sub>	7601-54-9	21.1
4	Натрийн гипохлорит	Sodium hypochlorite	NaClO	7681-52-9	0.19
5	Натрийн бисульфид	Sodium hydrosulfate	NaHSO <sub>4</sub>	7681-38-1	0.75
6	Нимбэгний хүчил	Citric acid	C <sub>6</sub> H <sub>8</sub> O <sub>7</sub>	77-92-9	0.04
7	Хаг хурдас удаашруулагч	Flospere 3031BH	-	7446-81-3	5.3
8	Флоккулянт	Floram AN934SH (Anionic water soluble polymer)	-	-	0.33
9	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	0.15
10	Натрийн хлорид	Sodium chloride	NaCl	7647-14-5	411



ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,  
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,  
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-10-19

Дугаар: 0002270

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9012001004

Регистрийн дугаар: 2546191

Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, 0

Утас: 343024, 341901

Дараах химийн хортой, аюултай бодис:  
Ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
хүртгэл хугацаагаар олгов.

зөвшөөрлийг 2022.10.17-2026.12.31

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 45 нэр төрөл бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: -----

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
Төрийн нарийн бичгийн дарга


 Э. БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

 Ц. БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг  
Ашиглах 0002270 дугаартай  
тусгай зөвшөөрлийн хавсралт**

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, кг
1	Хүхрийн хүчил	Sulfuric acid	H <sub>2</sub> SO <sub>4</sub>	7664-93-9	50
2	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	36
3	Азотын хүчил	Nitric acid	HNO <sub>3</sub>	7697-37-2	3
4	Хурган чихний хүчил	Oxalic acid dehydrate	H <sub>2</sub> C <sub>2</sub> O <sub>4</sub> .2H <sub>2</sub> O	6153-56-6	5
5	Борын хүчил	Boric acid	H <sub>3</sub> BO <sub>3</sub>	10043-35-3	2
6	Натрийн гидроксид	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	0.5
7	Калийн гидроксид	Potassium hydroxide	KOH	1310-58-3	0.5
8	Натрийн хлорид	Sodium chloride	NaCl	7647-14-5	5
9	Молибдат аммони	Ammonium heptamolybdate tetrahydrate	(NH <sub>4</sub> ) <sub>6</sub> Mo <sub>7</sub> O <sub>24</sub>	12054-85-2	15
10	Цагаан тугалганы хлорид	Stannium chloride dehydrate	SnCl <sub>2</sub> .2H <sub>2</sub> O	10025-69-1	3
11	Мөнгөний нитрат	Silver nitrate	AgNO <sub>3</sub>	7761-88-8	0.2
12	Гриссын урвалж	Griess reagent	-	-	0.5
13	Аммиак	Ammonium hydroxide	NH <sub>4</sub> OH	1336-21-6	9.1
14	Аммонийн хлорид	Ammonium chloride	NH <sub>4</sub> Cl	12125-02-9	5
15	Аммонийн сульфат	Ammonium sulfate	(NH <sub>4</sub> ) <sub>2</sub> SO <sub>4</sub>	7783-20-2	0.5
16	Аммонийн нитрат	Ammonium nitrate	NH <sub>4</sub> NO <sub>3</sub>	6484-52-2	0.5
17	Аммонийн тиоцианит	Ammonium thiocyanate	NH <sub>4</sub> CNS	1762-95-4	0.5
18	Аммонийн персульфат	Ammonium persulfate	(NH <sub>4</sub> ) <sub>2</sub> S <sub>2</sub> O <sub>8</sub>	7727-54-0	0.5
19	Натрийн сульфат	Sodium sulfate	Na <sub>2</sub> SO <sub>4</sub>	7757-82-6	0.5
20	Устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxide	H <sub>2</sub> O <sub>2</sub>	7722-84-1	1
21	Калийн дихромат	Potassium dichromate	K <sub>2</sub> Cr <sub>2</sub> O <sub>7</sub>	7778-50-9	0.5
22	Калийн хромат	Potassium chromate	K <sub>2</sub> CrO <sub>4</sub>	7789-00-6	0.5
23	Калийн иодид	Potassium iodide	KI	7681-11-0	0.5
24	Натрийн бикарбонат	Sodium bicarbonate	NaHCO <sub>3</sub>	144-55-8	10
25	Натрийн сульфид	Sodium sulphide hydrate	Na <sub>2</sub> S.9H <sub>2</sub> O	1313-84-4	0.5
26	Барийн хлорид	Barium chloride	BaCl <sub>2</sub> .2H <sub>2</sub> O	10326-27-9	0.5
27	Калийн нитрат	Potassium nitrate	KNO <sub>3</sub>	7757-79-1	0.5
28	Несслерийн урвалж	Nessler reagent	K <sub>3</sub> HgI <sub>4</sub> NaOH	-	16
29	Натрийн гидрофосфат	Sodium phosphate	Na <sub>2</sub> HPO <sub>4</sub> .12H <sub>2</sub> O	7558-79-4	0.5



30	Калийн гидрофосфат	Dipotassium hydrogen phosphate	$K_2HPO_4 \cdot 3H_2O$	7758-11-4	0.5
31	Металл цагаан тугалга	Tin	Sn	7440-31-5	0.5
32	Металл цайр	Zinc	Zn	7440-66-6	0.5
33	Натрийн тетраборат, Бура	Borax Decahydrate	$Na_2B_4O_7 \cdot 10H_2O$	1303-96-4	0.5
34	Глицерин	Glycerin	$C_3H_8O_3$	56-81-5	25.2
35	Салицилын хүчил	Salicylic acid	$C_7H_6O_3$	69-72-7	0.5
36	Натрийн салицилат	Sodium salicylate	$C_7H_4(OH)(COONa)$	54-21-7	0.5
37	Сульфосацилийн хүчил	Sulfosalicylic acid	$C_7H_6O_6S \cdot 2H_2O$	5965-83-3	0.5
4	мг/дм <sup>3</sup>		13.80	78.0	1.44	7.02	0.20	7.04	6.70	6.700	19.20	3.84	0.120	0.005	10.00	22.0	5.20	0.053	56.10
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.280								0.291	0.172	0.960	0.320	0.0064	0.0002	0.282	0.458	0.084	0.0011
7	мг/дм <sup>3</sup>		14.00	93.9	1.60	7.24	0.28	10.56	7.53	7.600	26.40	3.36	0.130	0.028	14.00	29.0	3.96	0.063	64.63
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.600								0.328	0.195	1.320	0.280	0.0070	0.0009	0.395	0.603	0.064	0.0014
8	мг/дм <sup>3</sup>		12.60	82.0	1.12	7.10	0.24	8.36	6.95	6.900	24.00	2.40	0.070	0.034	12.00	28.0	4.84	0.033	53.66
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.400								0.302	0.177	1.200	0.200	0.0038	0.0011	0.338	0.582	0.078	0.0007
10	мг/дм <sup>3</sup>		12.80	76.0	1.28	7.02	0.26	9.68	6.70	6.800	19.60	3.12	0.050	0.007	12.00	18.0	7.04	0.046	53.66
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.240								0.291	0.174	0.980	0.260	0.0027	0.0002	0.338	0.374	0.113	0.0010
11	мг/дм <sup>3</sup>		10.60	64.0	1.20	6.94	0.22	7.40	5.45	5.450	16.00	2.64	0.270	0.021	8.00	14.4	5.72	0.040	47.56
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.020								0.237	0.140	0.800	0.220	0.0145	0.0007	0.226	0.300	0.092	0.0009
12	мг/дм <sup>3</sup>		9.80	62.0	0.96	6.99	0.24	7.00	5.40	5.400	15.20	2.88	0.140	0.019	8.00	16.5	3.35	0.043	45.73
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.000								0.235	0.138	0.760	0.240	0.0075	0.0006	0.226	0.343	0.054	0.0009
16	мг/дм <sup>3</sup>		12.8	60.0	0.88	6.78	0.26	7.20	5.30	5.300	14.80	2.16	0.120	0.024	6.00	13.2	8.85	0.017	42.68
	мг-эқв/дм <sup>3</sup>	0.920								0.231	0.136	0.740	0.180	0.0064	0.0007	0.169	0.275	0.142	0.0004
18	мг/дм <sup>3</sup>		12.2	80.0	1.28	6.92	0.21	8.40	6.80	6.800	21.76	3.26	0.320	0.028	12.00	21.0	5.90	0.030	58.54
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.360								0.296	0.174	1.088	0.272	0.0172	0.0009	0.338	0.437	0.095	0.0006

Дулааны 3-р цахилгаан станцын үүсгэвэр усны (гүний хурднуудын) 2022 оны 3-р улирлын дундаж үзүүлэлтүүд

Скваж №	Хэмжих нэгж	Гүрэнхийн хатуулаг	Цахиурын исэл	Давслаг	Исэлдэх чанар	pH	NH <sub>4</sub>	CO <sub>2</sub>	Катионууд							Анионууд				
									Na <sup>+</sup>	K <sup>+</sup>	Ca <sup>2+</sup>	Mg <sup>2+</sup>	Fe <sup>3+</sup>	Cu <sup>2+</sup>	Cl <sup>-</sup>	SO <sub>4</sub> <sup>2-</sup>	NO <sub>3</sub> <sup>-</sup>	NO <sub>2</sub> <sup>-</sup>	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	
1	мг/дм <sup>3</sup>		10.80	75.9	2.00	7.03	0.35	9.24	5.00	5.000	16.80	2.64	0.040	0.100	8.00	14.6	2.31	0.023	51.22	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.060					0.218		0.0021	0.0031	0.226	0.304	0.0005	0.840						
2	мг/дм <sup>3</sup>		13.80	99.7	0.40	7.11	0.39	10.56	6.80	6.70	19.60	4.80	0.080	0.300	10.00	25.0	5.28	0.089	58.54	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.380					0.296		0.0043	0.0094	0.282	0.520	0.0019	0.960						
3	мг/дм <sup>3</sup>		13.80	128.5	0.80	7.15	0.35	10.56	10.30	10.270	25.20	4.32	0.060	0.100	14.00	29.0	3.30	0.063	78.05	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.620					0.448		0.0032	0.0031	0.395	0.603	0.053	1.280						
4	мг/дм <sup>3</sup>		14.20	136.0	1.20	7.21	0.51	9.24	11.10	11.100	30.40	3.84	0.050	0.200	16.00	35.0	2.97	0.050	84.15	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.840					0.483		0.0027	0.0062	0.451	0.728	0.048	1.380						
7	мг/дм <sup>3</sup>		13.20	108.0	1.20	7.16	0.38	12.30	7.82	7.820	23.20	4.32	0.080	0.100	12.00	24.0	2.64	0.040	71.95	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.520					0.340		0.0043	0.0031	0.338	0.499	0.043	1.180						
8	мг/дм <sup>3</sup>		13.00	67.2	0.80	7.19	0.42	8.80	4.60	4.600	15.20	1.68	0.070	0.200	7.00	11.0	1.98	0.033	46.34	
	мг-эқв/дм <sup>3</sup>	0.900					0.200		0.0038	0.0062	0.197	0.229	0.032	0.760						
10	мг/дм <sup>3</sup>		14.40	67.2	2.40	7.14	0.43	11.40	4.70	4.680	15.60	1.68	0.070	0.100	8.00	10.2	1.65	0.030	47.56	
	мг-эқв/дм <sup>3</sup>	0.920					0.204		0.0038	0.0031	0.226	0.212	0.027	0.780						
11	мг/дм <sup>3</sup>		11.8	64.0	1.20	7.08	0.38	9.24	4.72	4.750	13.20	3.60	0.020	0.200	7.30	12.5	1.32	0.023	48.78	
	мг-эқв/дм <sup>3</sup>	0.960					0.205		0.0011	0.0062	0.206	0.260	0.021	0.800						
16	мг/дм <sup>3</sup>		11.4	63.0	2.00	7.10	0.41	9.24	4.65	4.700	14.00	2.88	0.070	0.200	6.80	12.0	2.60	0.020	47.56	
	мг-эқв/дм <sup>3</sup>	0.940					0.202		0.0038	0.0062	0.192	0.250	0.042	0.780						
18	мг/дм <sup>3</sup>		12.60	60.6	1.20	7.14	0.42	10.56	4.90	4.900	14.80	3.36	0.120	0.100	7.20	13.4	2.31	0.017	51.22	
	мг-эқв/дм <sup>3</sup>	1.020					0.213		0.0064	0.0031	0.203	0.279	0.037	0.840						

Шинжилгээний дүнг нэгтгэсэн:

“ДЦС-3” ТӨХК-ийн Үйлдвэрлэлийн экологийн инженер

Э.Энхбат



ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Г Ариун цэврийн комиссыг томилох Г  
тухай

Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2; Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.4.8; Ариун цэврийн журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ариун цэврийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулсугай.

Үүнд:

Комиссын дарга:

Аж ахуй эрхэлсэн дэд захирал

Нарийн бичгийн дарга:

Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан

Гишүүд:

Үйлчилгээ аж ахуйн хэсгийн дарга

Бүтээмж, чанар хариуцсан мэргэжилтэн


Соёл үйлчилгээний зааварлагч

Цехийн дарга нар

2. Ариун цэврийн комиссыг удирдлагаар хангаж, Ариун цэврийн журмын хэрэгжилтэд байнга хяналт тавьж мөрдөн ажиллахыг /Комиссын дарга/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/126 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЭРХБААТАР



## “БОАД” ХХК

Байгаль Орчны Аудит, зөвлөх үйлчилгээний  
мэргэжлийн байгууллага

## “ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2022-05-17 № 22/10

танай \_\_\_\_\_-ныг № \_\_\_\_\_-т

### Удиртгал:

“БОАД” ХХК болон “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн хооронд байгуулсан 2-3-161/22 дугаартай “Байгаль орчны аудит хийлгэх ажлын гэрээ”-ний дагуу 2022 оны 04 сарын 01 өдрөөс эхлэн 2022 оны 05 сарын 15-ны хооронд “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагаанд 5 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10<sup>1</sup> зүйлийн дагуу БОАЖСайдын 2019 оны А-809 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”, “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал” болон Компанийн өөрийн боловсруулсан “Эрсдэлд суурилсан аудитын нарийвчилсан арга зүй”-г мөрдлөг болгон ажиллалаа. Аудитын үр дүнг үнэлэхдээ Нийцэл, Үл нийцэл болон Хугацаа болоогүй гэсэн 3 үнэлэмжийг ашигласан. Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд нийцэл, батлагдаагүй тохиолдолд үл нийцэл, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд хугацаа болоогүй гэсэн үнэлэмжид хамаарна. Байгаль орчны аудитын газар дээрх үзлэгийг 2022 оны 04-р сарын 15-аас 2022 оны 5-р сарын 10-ны хооронд “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтэстэй хамтран хийв.

### Аудитын зорилго:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт байрлах “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагаанд 2-3-161/22 дугаартай гэрээний дагуу дараах үндсэн 6 чиглэлд байгаль орчны аудитыг гүйцэтгэв.

1. Усан орчны менежмент
2. Хөрсөн орчин ба газрын менежмент
3. Агаар орчин, хийн ялгаруулалтын менежмент
4. Хог хаягдлын менежмент
5. Хими болон аюултай бодисын менежмент
6. Биологийн олон янз байдлын менежмент

Дээрх чиглэлүүдэд байгаль орчны нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцлийг залруулах төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн зөвлөмж өгөх зорилготой.

### Аудитын төрөл:

- ~ Байгаль орчны нийцлийн төлөвлөгөөт аудит

### Байршил ба хугацаа:

Дараах байршлуудад аудитын үйл ажиллагаа явагдав. Үүнд:

- ~ Төсөл хэрэгжиж буй газар буюу Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн нутаг дахь “Дулааны гуравдугаар цахилгаан станц”.
- ~ Аудитыг 2022 оны 4 сарын 1 өдрөөс эхлэн 2022 оны 5 сарын 15-ны хооронд нийт 45 хоног, газар дээрх аудитыг 2022 оны 4-р сарын 15-21-ны өдрүүдэд гүйцэтгэсэн.







**Аудитын хамрах хүрээ:**

1. Цаг хугацааны хувьд:  
Нийт 45 хоног
2. Орон зайн хувьд:  
“Дулааны гуравдугаар цахилгаан станц”
3. Бичиг баримтын хувьд:  
Захиалагч байгууллагаас хангагдсан бичиг баримт ба тухайн байгууллагын цахим хуудас. Гуравдагч этгээдээс бичиг баримт авахгүй, түүнийг аудитын шалгуурт тооцохгүй. Хууль тогтоомжийн хувьд тухайн аудитор өөрийн аудит хийж буй чиглэлийн хууль тогтоомжийг бүрдүүлнэ.
4. Объектын хувьд:  
Дулааны гуравдугаар цахилгаан станцын үйл ажиллагаа явагдаж буй цех, тасаг, үнсэн сан, ус хангамжийн худгууд, эргэлтийн саарал усны сан.
5. Хууль тогтоомжийн хүрээнд:  
Монгол Улсын хууль тогтоомжийг аудитын шалгуур тогтооход ашигласан. Аудитын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хүчин төгөлдөржилтийн цаг хугацааны хамрагдалт нь 2022-04-01 хүртэлх хугацаагаар хязгаарлахаар тохиролцсон. Өөрөөр хэлбэл, 2022-04-01-ээс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгохгүй. Мөн 2022-04-01-ээс өмнө батлагдаад одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн заалтууд аудитын шалгуур болно. Түүнчлэн БОАЖЯ-аар батлагдсан сүүлийн 2 жилийн БОННУ, БОМТ нь аудитын шалгуур тогтооход ашиглагдсан.
6. Хуулийн этгээдийн хүрээнд:  
Зөвхөн захиалагч байгууллагын хүрээнд хийгдэх ба туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгдэхгүй. Өөрөөр хэлбэл, захиалагч байгууллагад аливаа бараа материал нийлүүлдэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа хамаарахгүй ба тухайн байгууллагын захиалагчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээ, бичиг баримтын бүрдэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний тайлан гэх мэтийг үзнэ. Дээрх зүйлст аливаа үл нийцэл илэрвэл түүнийг цаашлуулан гэрээлэгч байгууллагад аудит хийхгүй, зөвхөн үл нийцлийг тайландаа тусгаж, түүнд аудит хийлгэхийг зөвлөмж хэлбэрээр бичнэ.

**Аудитад хамрагдаагүй хэсэг:**

Тус аудитад дараах зүйлс хамрагдаагүй:

- ~ Цаг хугацааны хувьд газар дээрх аудит хийснээс хойш хугацаанд болсон аливаа үйл ажиллагаа
- ~ Орон зайн хувьд станцаас өөр газарт болсон аливаа үйл ажиллагаа
- ~ Бичиг баримтын хувьд гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, түүнийг аудитын шалгуурт тооцоогүй.
- ~ Объектын хувьд үндсэн болон туслах үйл ажиллагаанд хамааралгүй аливаа объект
- ~ Хууль тогтоомжийн хувьд 2022-04-01-ээс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгоогүй.
- ~ Хуулийн этгээдийн хүрээнд үйлчлүүлэгчээс бусад этгээд хамаарахгүй, мөн үйлчлүүлэгчийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй.





**Аудитын шалгуур:**

Нийт 310 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны нийцлийн аудитыг гүйцэтгэв. Эдгээрээс 203 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, үндэсний хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, аргачлал, стандартад, 107 нь БОННУ болон БОМТ-нд тусгалаа олсон бөгөөд 3 нь төслийн үйл ажиллагаанд хамааралгүй байв.

**Баталгаажсан нотолгоо:**

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 276 багц нотолгоог аудитын явцад цуглуулав.

**Аудитын үнэлэмж:**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан. Нийт 307 шалгуурыг цуглуулсан нотолгоонууд дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулсан.

**Аудитын дүгнэлт:**

Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дахь “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн байгаль орчны үйл ажиллагааны 79.2% нь үндэсний хууль тогтоомжид нийцэлтэй байна. Хугацаа болоогүй буюу тухайн шалгуурыг гүйцэтгэх цаг хугацаа болоогүй байгаа тул тэдгээрийг шууд үл нийцэл гэж ойлгохгүй бөгөөд тус байгууллага ирээдүйд түүнийг гүйцэтгэнэ гэдэг итгэлтэй байна.

Тус компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн биелэлтийг хангаад зогсохгүй олон улсын ISO холбогдох стандартын шаардлагыг биелүүлдэг давуу талтай. Үүнд:

1. Монгол улсын Байгаль орчны хууль, дүрэм журам, стандартууд
2. Олон улсын ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцооны шаардлагад нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

БОАЖ-ын Сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.15-р зүйлд заасны дагуу Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дахь “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн байгаль орчны нийцэл нь 79.2% байна.

**Ерөнхий зөвлөмж:**

Аудит хийгдсэн үндсэн 6 чиглэл тус бүрийн зөвлөмжүүд тайлангийн дараагийн бүлгүүдэд туссан бөгөөд “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн зүгээс дараагийн аудитыг 2024 онд хийлгэх хэрэгтэй. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” хувьд хог хаягдлын менежментийн асуудал хамгийн эрсдэлтэй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

**Эргэн шалгалтын төлөвлөгөө:**

Байгаль орчны аудитын шалгуурын явцад үл нийцэлтэй гарсан үнэлэмжүүдийг залруулах ажлын төлөвлөгөөг аудитын байгууллага боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацааг захиалагч байгууллага өөрөө тогтоосон бөгөөд аудитын эргэн шалгалтыг үйлчлүүлэгч дотоодын хянан шалгалтаар гүйцэтгэж, биелэлтийг тооцохоор тохиролцов.

**Аудитын нууцлал:**

Байгаль орчны аудитын ёс зүй, хөндлөнгийн хараат бус байх, мөн үйлчлүүлэгчийн нууцыг дараагийн аудит хийх хүртэл хадгалах зарчмыг баримтлан аудитын үеийн мэдээлэл, тайлан, нотолгоо зэргийг гуравдагч этгээдэд танилцуулахгүй бөгөөд шүүхийн шийдвэрээр үйлчлүүлэгч талд мэдэгдсэний үндсэн дээр эсвэл төрийн захиргааны байгууллагын бичгээр ирсэн албан шаардлагын дагуу аудит захиалагч байгууллагаас бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр эсвэл уг мэдээлэл аудитын байгууллагаас бусад этгээдээр дамжин олон нийтэд ил болж, нууц биш болох нь нотлогдсон тохиолдолд аудитын үеийн мэдээллийг задруулна.





“БОАД” ХХК - Байгаль Орчны Аудит, зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага

**Тайлан түгээлт:**

Байгаль орчны аудитын үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан аудитын тайланг зөвхөн үйлчлүүлэгч талд хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Уг тайланг цааш гуравдагч этгээдэд түгээх эсэхээ үйлчлүүлэгч өөрөө шийдэх эрхтэй. Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 1-р заалтыг үндэслэн Байгаль орчны төлөвлөгөөт аудитын товч тайлан, Аудитын үл нийцлийг залруулах төлөвлөгөөний биелэлтийн тайланг аудитын үйлчлүүлэгч Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлнэ.

АХЛАХ АУДИТОР



О.АЛТАНСҮХ





НИЙСЛЭЛИЙН  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/ССЭ

Улаанбаатар хот

Хаягдал ус хаях цэг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.8, 24 дүгээр зүйлийн 24.2, 24.5, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А/406/226 дугаар хамтарсан тушаал, Усны газрын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 92 дугаартай "Хаягдал усны дүгнэлт"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэх станцын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн унд ахуйн хаягдал ус, технологид нөхөн сэлбэлтээр авч ашигласан хаягдал ус, технологид тунгаах сангаас эргүүлэн авч ашигласан хаягдал усыг хаягдал усны дүгнэлтийн дагуу тогтоосон цэгт хаяхыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуульд заасан үүргээ биелүүлж, холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрчилгээг сунгуулан усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай холбогдох мэдээ, тайлан, хаягдал ус хаях зөвшөөрөл, ус бохирдуулсны төлбөр төлсөн баримтыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ХХК (Л.Эрхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

В.ЦЭРЭН




1170001730

БАТЛАВ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Д.НЯМДОРЖ

УЛААНБААТАР  
"ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН  
СТАНЦ" ТӨХЖИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ ГУРАВДУГААР  
ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨХ



Л.ЭРХБААТАР

## ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар ХУТ 221/  
2-3-358/22

Улаанбаатар хот

### Нэг: Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу "Усны газар"-ын гаргасан 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 92 дугаартай хаягдал усны дүгнэлт, Туул голын сав газрын захиргаанаас олгосон 2022 оны 11-р сарын 14-ний өдрийн ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороонд байрлах 9012001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 2546191 тоот регистрийн дугаартай "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийг төлөөлж ерөнхий инженер П.Болдбаатар нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 /Нэг/ жилийн хугацаатай байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтээр тогтоосон ус бохирдуулсны төлбөр болох 20'322'331.74 /Хорин сая гурван зуун хорин хоёр мянга гурван зуун гучин нэгэн төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөгийг гэрээний 2.3-т заасан хугацаанд төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор үндсэн бүртгэлтэй харьяалах Татварын албанд /Аж ахуйн нэгжийн үндсэн бүртгэлийн дагуу/ төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутам Сав газрын захиргаа, харьяалах Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинаар байгальд хаясан хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал, шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

2.4.7. 2.4.1-ээс 2.4.4-т заасан мэдээллийг Tuul.info20@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

#### **Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг**

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дэхь хэсэгт заасны дагуу Сав газрын газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно. /Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/552 дугаартай захирамж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06/1124 тоот албан бичгийг тус тус заагдсан 47°53'13,2334", 106°50'16,48828" цэгт шаардлагатай тохиолдолд хаягдал ус зайлуулах.

3.3. Сав газрын захиргаа болон сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

#### **Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг**

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

#### **Тав. Бусад**

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **Зургаа. Давагдашгүй хүчин зүйл**


6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт) –ийн


нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсоныг нотолно.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Туул голын сав газрын захиргааны  
Менежер  Д.Жаргал

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
Албаны даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч  П.Энхбаяр


#### УС БОХИРДУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер  П.Болдбаатар

Үйлдвэрлэлийн албаны дарга  
 Л.Бөхболд

Техникийн бодлогын хэлтсийн  
дарга  Г.Амартүвшин

Хуулийн мэргэжилтэн  Ц.Оюун-Эрдэнэ

Гэрээний мэргэжилтэн  
 Г.Батням

Холбоо барих утас: 976-11-343024,  
9900-6727

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

## ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 22/10

### УСНЫ ГАЗАР

/ Дүгнэлт гаргасан байгууллага / ..... -ын гаргасан

2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах ...92... тоот

дүгнэлтийг үндэслэн ..... Улаанбаатар ..... аймаг/нийслэл ..... Хан-Уул...

сум/дүүргийн ..... 3 дугаар хороонд ..... байршилтай

/ хаяг /

### Эрчим хүчний үйлдвэрлэл

/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа ДУЛААНЫ 3-Р ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-Д

/ хүн, хуулийн этгээдийн нэр /

..... Улаанбаатар ..... аймаг/нийслэл, ..... Хан-Уул ..... сум/дүүргийн

106°50'16.48828" 47°53'13.2334"

байршилтай хаягдал

ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны

шугамд жинд ..... 3:903.0 ..... мян.м<sup>3</sup> хаягдал усыг "Хүрээлэн байгаа

орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015",

"Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд

нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар

тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг

/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон

дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.

Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны

шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

ТУУЛ ГОЛЫН САВ

ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

/ Зөвшөөрөл олгосон байгууллага /

Тамга

Зөвшөөрлийн бичиг олгосон:





/ Гэрэн үсэг /

..... Д.НЯМДОРЖ.....

/ Гэрэн үсгийн тайлал /

20 22 оны 11 -р сарын 14 -ны өдөр





## ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ АЖЛЫН ГЭРЭЭ

2022 оны 11-р сарын 25-ны өдөр

Дугаар 2-3-357/22.

Улаанбаатар хот

Нэг талаас "ДЦС-3" ТӨХК-ийг төлөөлөн Ерөнхий инженер П.Болдбаатар (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Ойн хайгуул" ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Б.Сарангуа (цаашид "Гүйцэтгэгч" гэх) дараах нөхцөл, зүйлийг харилцан тохиролцож Иргэний хуулийн 243-261 дэх заалт, Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ДЦС3/202206192 дугаартай тендерт Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1. Захиалагч Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих (ДЦС3/202206192) (цаашид "ажил" гэх)-ыг 87,458,838.00 (наян долоон сая дөрвөн зуун тавин найман мянга найман зуун гучин найман) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
2. Гэрээний нийт дүн: 87,458,838.00 (наян долоон сая дөрвөн зуун тавин найман мянга найман зуун гучин найман) төгрөг байна. Урьдчилгаа төлбөр 30 хүртэл хувийг гэрээ байгуулсаны өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн олгоно.
3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн хийж гүйцэтгэн Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
4. Гүйцэтгэгч нь ажлын явцад ажиллаж буй ажилтнуудад өдөр тутам хийх ажлын онцлог, гарч болох эрсдлийн талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, ажлын байрны аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллаагүйгээс үүссэн эрсдэлийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 5.2. Үнийн санал;
  - 5.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 5.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 5.5. Ажлын даалгвар
  - 5.6. Гүйцэтгэлийн баталгаа

*Болдбаатар*

- 5.7. Ажил гүйцэтгэх хуваарь.
6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
  7. Захиалагч, Гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
  8. Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу Захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.
  9. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хариуцлага хүлээнэ.
  10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, телекс, факсаар харилцана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Ерөнхий инженер  
..... П.Болдбаатар

Төлөвлөлт эдийн засгийн  
хэлтсийн дарга  
..... Л.Оюун-Эрдэнэ

Техникийн бодлогын хэлтсийн  
дарга  
..... Г.Амартүвшин

Ерөнхий нягтлан бодогчийн  
үүргийг түр орлон гүйцэтгэгч  
..... Ө.Энхбаяр

Гэрээний мэргэжилтэн  
..... Г.Батням

Хянасан:  
Хуулийн мэргэжилтэн  
..... Л.Оюун-Эрдэнэ

ХУД, 3- хороо, "ДЦС-3" ТӨХК  
өөрийн байр


Утас: 341991, 343575, 341717  
Факс: 343024

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Ерөнхий инженер  
..... Д.Оюунцэцэг

УБ хот, Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, төмөрчний гудамж  
Геозэкологийн хүрээлэн 305 тоот  
Утас: 99240226, 99243535  
РД: 2543281  
Банк: .....  
Данс: .....

БАТЛАВ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ОЮУНБОЛД

2022 оны 03 дугаар сарын 01

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
"ДУЛААНЫН ЦАХИЛГААН СТАНЦ"  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Л.ЭРХБААТАР

2022 оны 03 дугаар сарын ...

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 22/02

2-3-130/20

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Усны газар"-ын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 05/140 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 09 тоот ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн АБ. дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны Ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах, Улсын бүртгэлийн 9012001004 тоот гэрчилгээ, 2546191 тоот регистрийн дугаартай "Дулааны 3-р цахилгаан станц" ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер П.Болдбаатар нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2022 оныг дуустал байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Цахилгаан болон дулааны эрчим хүч, үйлдвэрт ашиглах уур үйлдвэрлэх техник, технологийн болон ажиллагсдын унд, ахуйн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 9'952'071.1 м<sup>3</sup>/жил;

2.2.1. Унд-ахуйд: 54'421.5 м<sup>3</sup>/жил;

2.2.2. Цахилгаан үйлдвэрлэхэд: 452'518.72 м<sup>3</sup>/жил;

2.2.3. Дулаан үйлдвэрлэхэд: 8'297'649.56 м<sup>3</sup>/жил;

2.2.4. Уур үйлдвэрлэхэд: 516'000.0 м<sup>3</sup>/жил;

2.2.5. 1'600'000.0 м<sup>3</sup> усыг эргэлтийн усан сангаас технологийн хэрэгцээнд эргүүлэн ашиглана.

2.3. *Усны чанар, найрлага:* Ашиглагдаж байгаа 14 худаг тус бүрээс улирал тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Сонсголонгийн гүүрнээс баруун тийш Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт, Туул голын хойд эргийн дагуу байрлах 18 гүний худагтай. 1979 онд "ПНИИИС" газрын доорх усны ашиглалтын нөөцийг 41'400.0 м<sup>3</sup>/хон, 2013 онд "Цэнхэр-Эрдэнэ" ХХК 32'400.0 м<sup>3</sup>/хон гэж тооцсон байна. Одоогоор нийт 14 худгийг ашиглаж байгаа бөгөөд 5, 6, 13, 14 дугаартай худгуудын ундарга муудсан учир ашиглахгүй.

2.4.2. *Барилга байгууламж:* Техникийн ус нөөцлөх 1'000.0 м<sup>3</sup> багтаамжтай 2 сан бүхий өргөлтийн насос станц, 846'000.0 м<sup>3</sup> эзлэхүүн бүхий үнсэн сан 1, тунгаагдсан усыг нөөцлөх 124'000.0 м<sup>3</sup> багтаамжтай сан 1, галын аюулгүй байдлыг хангах 250 м<sup>3</sup> багтаамжтай 2 сантай. Шинээр баригдсан үнсэн сангийн эзлэхүүн 780'000.0 м<sup>3</sup>.

ТУУЛ ГОЛЫН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 01

2.4.3. Цахилгаан станцын ачаалал болон аваар ослын улмаас хаягдлын сан халих эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, байнгын хяналт тавих. Эрсдэлээс үүдэн гарах хохирлыг байгууллага бүрэн хариуцахыг анхаарах.

2.4.4. *Тоног төхөөрөмжийн нэр, марк:* Дунд даралтын станц нь БКЗ-75-39 маркийн 6 уурын генератор, ПТ-12-35 маркийн 4 турбинтэй, өндөр даралтын станц нь БКЗ-220-10 маркийн 7 уурын генератор, ПТ-25-90 маркийн 4 турбин, С-50/8.83-2.9 маркийн 1 турбинтэй.

2.4.5. *Насосны хүчин чадал:* ЭЦВ12-160-65 насосоор 2 худгийг, грундфос SP160-4 маркийн насосоор 12 худгийг, үнсэн далангаас технологийн ус эргүүлэн татах станц нь Д-500-65 УХЛ маркийн 4 насосоор тоноглогдсон.

2.5. *Хаягдал усны хэмжээ:*

2.5.1. *Стандартын шаардлага:* Технологийн хаягдал бохир усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартыг мөрдлөг болгоно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:* Станцаас баруун тийш 1.1 км зайд байрлах хуучин үнсэн сангийн багтаамж 846'000.0 м<sup>3</sup>, шинэ үнсэн сангийн багтаамж 780'000.0 м<sup>3</sup>, хоногт 2'500.0-3'000.0 м<sup>3</sup> усыг шүүрлийн байгууламжаар дамжуулан дахин ашиглана.

Үнсэн сангийн координат:

Үнсэн сан 47° 53' 30.47", 106° 50' 56.49"

Шүүрлийн усны сан 47° 53' 32.70", 106° 50' 33.06"

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:* Усны тухай хуулийн 30.1.2 дахь хэсэгт заасны дагуу усны хэрэглээ хариуцсан Ус ашиглалтын менежер ажиллуулна.

2.7.1. Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 10 дугаар худаг /нөөц худаг/-т суурилуулсан түвшин хэмжигчийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.8. *Усны тоолуур:* Ус цуглуулах 720 мм голчтой хос шугам дээр UFM-005 маркийн электрон усны тоолууртай. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1-р шугамын заалт 5'760'894.0 м<sup>3</sup>, 2-р шугамын заалт 5'691'892.0 м<sup>3</sup>.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Эрчим хүчний үйлдвэрлэлд нийт ашиглах 9'897'649.56 м<sup>3</sup> уснаас эргүүлэн ашиглах 1'600'000.0 м<sup>3</sup> усыг нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлнө. Төлбөр тооцогдох 8'297'649.56 м<sup>3</sup> газрын доорх усны нөөц ашиглах төлбөрт 587'473'589.0 /Таван зуун наян долоон сая дөрвөн зуун далан гурван мянга таван зуун наян есөн/ төгрөгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

2.9.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ тоолуурын заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр сар бүр тооцож, орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

2.9.3. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.

### Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүдгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 7.1, 7.15 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.


4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Ус ашиглуулагч нь 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Тайлант оны 12 дугаар сарын 20-ны дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлдэг ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.



### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ  
ТӨЛӨӨЛЖ:


Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны дарга

 П.МАГСАРЖАВ

Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах  
албаны Ахлах мэргэжилтэн

Б.БАТ-ЭРДЭНЭ


Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны Ахлах мэргэжилтэн

 П.ЭНХБАЯР


Утас: 70003716, 70003714, 70002592

"ДУЛААНЫ 3-Р ЦАХИЛГААН СТАНЦ"  
ТӨХЖ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Тэргүүн дэд захирал, Ерөнхий инженер

 П.БОЛДБААТАР

Үйлдвэрлэлийн албаны дарга

 Л.БӨХБОЛД


Техникийн бодлогын хэлтсийн дарга

 Г.АМАРТҮВШИН

Хуулийн мэргэжилтэн

 Ц.ОЮУН-ЭРДЭНЭ


Гэрээний мэргэжилтэн

 Г.БАТНЯМ

Утас: 976-11-343024, 99001531.

БАТЛАВ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Д.НЯМДОРЖ



ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ  
БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр

Дугаар ХУТ 22/

Улаанбаатар хот

Нэг: Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу "Усны газар"-ын гаргасан 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 92 дугаартай хаягдал усны дүгнэлт, Туул голын сав газрын захиргаанаас олгосон 2022 оны 09-р сарын ...-ны өдрийн ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороонд байрлах 9012001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 2546191 тоот регистрийн дугаартай "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийг төлөөлж ерөнхий инженер П.Болдбаатар нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 /Нэг/ жилийн хугацаатай байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтээр тогтоосон ус бохирдуулсны төлбөр болох 20'322'331.74 /Хорин сая гурван зуун хорин хоёр мянга гурван зуун гучин нэгэн төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөгийг гэрээний 2.3-т заасан хугацаанд төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор үндсэн бүртгэлтэй харьяалах Татварын албанд /Аж ахуйн нэгжийн үндсэн бүртгэлийн дагуу/ төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутам Сав газрын захиргаа, харьяалах Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинаар байгальд хаясан хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал, шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

2.4.7. 2.4.1-ээс 2.4.4-т заасан мэдээллийг Tuul.info20@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

### **Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг**

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дэхь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

### **Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг**

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

### **Тав. Бусад**

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **Зургаа. Давагдашгүй хүчин зүйл**


6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт) –ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсоныг нотолно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

## УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Туул голын сав газрын захиргааны

Менежер  Д.ЖаргалУсны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
Албаны даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч  П.Энхбаяр


## УС БОХИРДУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер

 П.Болдбаатар

Үйлдвэрлэлийн албаны дарга

Л.Бөхболд

Техникийн бодлогын хэлтсийн  
дарга  Г.Амартүвшин


Хуулийн мэргэжилтэн

Ц.Оюун-Эрдэнэ


Гэрээний мэргэжилтэн

 Г.БатнямХолбоо барих утас: 976-11-343024,  
9900-6727, 9900-9679





Л.ЭРХБААТАР



Н.БИЛГҮҮН

### ХИМИЙН УРВАЛЖ ШИЛ САВ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны 04-р сарын 21-ны өдөр

Дугаар 1-3-211/22

Улаанбаатар хот

Нэг талаас "ДЦС-3" ТӨХК-ийг төлөөлөн Тэргүүн дэд захирал, Ерөнхий инженер П.Болдбаатар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Цэцүүх трейд" ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Н.Билгүүн (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах нөхцөл, зүйлийг харилцан тохиролцож Иргэний хуулийн 243-261 дэх заалт, Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Бараа" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь 106,867,050.00 (Нэг зуун зургаан сая найман зуун жаран долоон мянга тавин) төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч "Цэцүүх трейд" ХХК-ийн харилцах ХААН банкны 5115001011 дугаар дансанд шилжүүлнэ.
3. Нийлүүлэгч нь 91 нэр төрлийн химийн урвалж шил савыг гэрээ байгуулсан өдрөөс хойш 45 хоногийн дотор багтаан нийлүүлэх хуваарийн дагуу нийлүүлнэ.
4. Хүлээн авах бараатай холбогдох элдэв өөрчлөлтийг Захиалагч шууд Нийлүүлэгч талтай хэлэлцээр хийн баримт бичиг үйлдэж гэрээний бусад шаардлагатай баримт бичиг болгон хавсаргана.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 5.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 5.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 5.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 5.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 5.6. Техникийн тодорхойлолт;
  - 5.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.Гэрээ нь 5.1 – 5.7-д дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлэх үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын

*Билгүүн*

дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
9. Нийлүүлэгч тендерийн бичиг баримтад нийлүүлэхээр санал болгосон барааг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлнэ. Зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Тэргүүн дэд захирал, Ерөнхий инженер

..... П.Болдбаатар

Хангамжийн хэлтсийн дарга

..... Г.Төмөрбаатар

Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... Э.Энхбаяр

Хими цехийн дарга

..... Е.Цогтбаяр

Гэрээний мэргэжилтэн

..... Г.Батням

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

..... Ц.Оюун-Эрдэнэ

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Санхүү, Худалдаа хариуцсан Захирал

..... Б.Даваажав

Борлуулалтын ахлах менежер


..... Б.Солонго

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3- хороо, "ДЦС-3"  
ТӨХК-ийн өөрийн байр

Утас: 341991, 343575, 341717  
Факс: 343024

Хаяг: УБ хот, БГД, 5-хороо  
Энхтайваны өргөн чөлөө  
64/2 тоот

Утас: 7018-0631  
РД: 2066521  
Банк: ХААН БАНК  
Данс: 5115001011



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Огноо: 2022 оны 09 сарын 19



Гэрээний дугаар: Ш-22/MS 23-8-328/22

Хүлээн авагч:  
“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/,  
Энхтайвны өргөн чөлөө 64/2 тоот  
“Цэцүүх” оффис, үйлчилгээний төв  
Утас: +976 70179777, +976 70180632  
Цахим хаяг: [www.tsetsuuh.mn](http://www.tsetsuuh.mn)  
Регистрийн дугаар: 2066521  
Цахим шуудан: [info@tsetsuuh.mn](mailto:info@tsetsuuh.mn)

Үүсгэгч:  
“ДЦС-3” ТӨХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-  
Уул дүүрэг, 3-р хороо /17070/, Чингисийн  
өргөн чөлөө  
Утас: 343024  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:  
00134813  
Регистрийн дугаар: 2546191  
Цахим шуудан: [ps3@tes3.energy.mn](mailto:ps3@tes3.energy.mn)



### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 19-ний өдөр

№ Ш-22/115  
У-2-3-8-328/02

Улаанбаатар хот

Нэг талаас Цэцүүх трейд ХХК /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас "ДЦС-3" ТӨХК-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Ерөнхий инженер албан тушаалтай П.Болдбаатар бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

#### Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

#### Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг сүлжэж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон үүсмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 2/10

2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

**Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл**

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны 09 сарын 19 өдрөөс 2023 оны 09 сарын 19 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл [info@tsetsuuh.mn](mailto:info@tsetsuuh.mn) хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
- 3.7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.8. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн Голомт банкны 1715132986 тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

**Дөрөв. Талуудын эрх, үүрэг**

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
  - 4.1.1 Үүсгэгч аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
  - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
  - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
  - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
  - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
  - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.

Хуудсыг баталгаажуулсан: \_\_\_\_\_

Хуудас 3/10



- 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
- 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

#### **Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах**

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.


#### **Зургаа. Өмчлөх эрх шилжих**

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.



Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 4/10



- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

#### **Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам**


- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **Найм. Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 5/10



### Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

ДЦС-3 ТӨХК-ийн Ерөнхий инженер

 П.Болдбаатар

ТЭЗХ-ийн дарга

 Л.Оюун-Эрдэнэ

Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр ордон гүйцэтгэгч

 О.Энхбаяр

Хими цехийн дарга


 Ё.Цогтбаяр

Гэрээний мэргэжилтэн

 Г.Батням

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

 Ц.Оюун-Эрдэнэ

Суурин утас: 11343024

Гар утас: 99006727

Регистер: 2546191

УБ гэрчилгээний дугаар: 000134813

Химийн бодис ашиглах, импортлох тусгай

зөвшөөрлийн дугаар: 0002198

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,

Чингисийн өргөн чөлөө

Email хаяг: ps3@tes3.energy.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн

Үйлдвэрийн дарга

 Б.Дарамбазар

Нягтлан бодогч

 Т.Буяндэлгэр

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,

Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх

Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn


Шуудангийн хаяг: ШХ-1138

9900 7671

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 6/10






Хавсралт № 01

2022-2023 онд "ДЦС-3" ТӨХК-ИЙН ЖИЛД УСТГУУЛАХ  
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Канистр /25л/	HDPE	60ш	60ш	60ш	60ш
2	Шуудай /50кг/		600ш	600ш	600ш	600ш
3	Шуудай /25кг/		180ш	180ш	180ш	180ш
4	Кардон цаас		10кг	10кг	10кг	10кг
5	Химийн бодисын хаягдал сав /0,5л, 1,0л/		60ш	60ш	60ш	60ш

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 7/10





**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ  
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ  
(тээврийн зардал багтаагүй үнэ болно)**


№	Үйлчилгээний төрөл	Хог хаягдлын төрлийн код	Зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ төг
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр 0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, 25л, 50л, 60л,	150109		1кг	1150
2	Химийн бодисоор бохирдсон тостой Цаасан болон кардонон сав баглаа боодол	150101		1кг	1150
3	Химийн хуванцар торх 100л	150109		1ш	4800
4	Химийн хуванцар торх 200л	150109		1ш	7900
5	Химийн хуванцар IBC танк 1000л	150109		1ш	26000
6	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас, автомашины агаар шүүгч фильтр	150201		1кг	1930

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 8/10

7	Полипропилен уут, шуудай, 25кг, 50 кг, 1 тн big bag шуудай/	150109		1кг	1380
8	Төмөр торх, сав 20л, 50л, 120л, 200л			1кг	900


Тайлбар. 1. Дээрх үнэнд химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар савыг хадгалах, дахин боловсруулах үйлчилгээний хөлс бөгөөд тээврийн зардал ороогүй болно.  
2. Химийн хортой бодис хадгалсан хуванцар савыг хүлээн авагч авахдаа жинлэж авах ба бага хэмжээтэй тохиолдолд тн-ийг килограммд шилжүүлж тооцно.



Хуудсыг баталгаажуулсан:

\_\_\_\_\_

Хуудас 9/10



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№


Дагалдах бичгийн дугаар:

/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

<b>1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:</b> Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: №166100 Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: .....								
<b>2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:</b>								
Овог нэр	Албан тушаалтан	Гарын үсэг:	Огноо:					
.....	.....	.....	2022 он .....					
сар.....өдөр								
<b>3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:</b> 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: ..... Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....								
<b>4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:</b>								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагааны бүлэг	Савны дугаар		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
1								
2								
3								
4								
<b>4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:</b>								
<b>6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :</b>								
1. Овог нэр:.....		Гарын үсэг:.....			2022 он .....			
сар.....өдөр								
<b>7. Үл зохицол:</b>								
<b>8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:</b> Аж ахуйн нэгжийн нэр: ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: Б-00007 У-001123 Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:								
Овог нэр : Цэцүүх трейд ХХК		Албан тушаал		Гарын үсэг/ тамга /		Огноо		
.....		.....		.....		2022 он .... сар		
... өдөр								

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 10/10



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК

## ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ



Огноо: 2022 оны 09 сарын 19  
Гэрээний дугаар: Т-22/090 2-3-8-327/22

Хүлээн авагч:  
“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайвны өргөн чөлөө 64/2 тоот “Цэцүүх” оффис; үйлчилгээний төв  
Утас: +976 70179777, +976 70180632  
Цахим хаяг: [www.tsetsuuh.mn](http://www.tsetsuuh.mn)  
Регистрийн дугаар: 2066521  
Цахим шуудан: [info@tsetsuuh.mn](mailto:info@tsetsuuh.mn)

Үүсгэгч:  
“ДЦС-3” ТӨХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо /17070/, Чингисийн өргөн чөлөө  
Утас: 343024  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000134813  
Регистрийн дугаар: 2546191  
Цахим шуудан: [ps3@tes3.energy.mn](mailto:ps3@tes3.energy.mn)



## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 19 өдөр

№Т-22/070 2-3-8-327/22 Улаанбаатар хот

Энэхүү гэрээ нь №Ш-22/115 тоот "Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ"-ний салшгүй хэсэг байна.

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас "Цэцүүх трейд" ХХК /цаашид "Тээвэрлэгч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, нөгөө талаас "ДЦС-3" ТӨХК /цаашид "Тээвэрлүүлэгч" гэх/-г төлөөлж Ерөнхий инженер албан тушаалтай Пүрэв овогтой Болдбаатар бид харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1,2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1 Энэхүү Гэрээгээр Тээвэрлэгч нь Тээвэрлүүлэгчийн даалгаврын дагуу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт орших "ДЦС-3" ТӨХК-с Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т тээвэрлэн хүргэх ажлыг энэ Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх, зохих ёсоор хүлээлгэн өгөх, Тээвэрлүүлэгч нь тээврийн хөлсийг төлөх, талууд эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг №... тоот "Аюултай хог хаягдал шилжүүлэх" гэрээ, Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.
- 1.2 Тээвэрлэгч ачаа, барааг тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг баримтлана.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Тээвэрлэлтийн гэрээний хугацаа 2022 оны 09 сарын 19 өдрөөс 2023 оны 09 сарын 19 өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байна.
- 2.2 Энэ гэрээ хэрэгжиж эхлэх огноонсоос эхлэн, гэрээний зүйлүүдийн дагуу хугацаанаас нь өмнө цуцлагдахаас бусад тохиолдолд, дуусгавар болох огноог дуусталх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.3 Гэрээний хугацааг гагцхүү талууд харилцан зөвшилцөж, бичгээр зөвшөөрсөний үндсэн дээр өөрчилнө.

### ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАХИАЛГА

- 3.1 Тээвэрлүүлэгч аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх захиалгаа тээвэрлэгчид албан бичгээр зөвөл [info@tsetsuuh.mn](mailto:info@tsetsuuh.mn) мэйл хаягаар өгнө. Тээвэрлүүлэгч нь Захиалга өгөх

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 2/7

- бүртээ тээвэрлүүлэх аюултай хог хаягдал болох хуванцар сав, уут шуудайны хэмжээ, ширхэг, жингийн талаарх мэдээллийг тээвэрлэгчид өгнө.
- 3.2 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн өгсөн аюултай хог хаягдлын мэдээллийг харгалзан үзэж хавсралт №1-д дурдсан тээврийн хэрэгслүүдээсээ сонгож тухайн тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.3 Тээвэрлүүлэгч захиалгаа өгсөнөөр талууд тээвэрлэлтийн хуваарийг 2 хоногийн дотор харилцан тохиролцож гаргана. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр тээвэрлэлтийн огноог хуанлийн 7 өдрөөр урагшлуулж, хойшлуулж болно.
- 3.4 Тээвэрлэлтийн хуваарь гарсанаас хойш тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн "ДЦС-3" ТӨХК-ээс Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т талбай дээр гэрээний 3.3-т заасны дагуу товлосон захиалга өгсөн өдөрт очсон байна.
- 3.5 Тээвэрлэгч Тээвэрлүүлэгчийн талбай дээр хүрэлцэн очсоноос хойш ... цагийн дотор Тээвэрлүүлэгч нь Тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд дагалдах бичигт дурдсан аюултай хог хаягдлаа ачиж өгнө.
- 3.6 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчээс аюултай хог хаягдлыг хүлээн авч тээвэрлүүлэгчийн талбайгаас гарсанаас хойш ... цагийн дотор хүлээн авагчийн Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэж өгнө.

#### ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Гэрээний талууд бичгээр өөрөөр харилцан тохиролцоогүй бол тээвэрлүүлэгч талаас тээвэрлэгчээр ачаа тээвэрлүүлсэн төлбөрөө цаг тухайд нь гэрээний хавсралт №1-д тусгасан тарифаар тооцож төлнө.
- 4.2 Тээвэрлэлтийн хөлсийг дараахи нөхцөлөөр зохицуулна.
- 4.2.1 Тээвэрлүүлэгч нь аюултай хог хаягдлаа тээвэрлүүлж хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор тээвэрлэгчийн нэхэмжлэхийн дагуу 100% төлбөрийг төлнө.
- 4.2.2 Төлбөр тооцоог тээвэрлэгчийн Голомт банк, "Цэцүүх трейд"ХХК, 1715132986 тоот дансаар шилжүүлнэ.

#### ТАВ. ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Тээвэрлэгчээр аюултай хог, хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргүүлэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэгтэй.
- 5.2 Аюултай хог, хаягдлыг тусгай зориулалт бүхий "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг тээвэрлэгчээс шаардах эрхтэй.
- 5.3 Тээвэрлүүлэгч аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхдөө Тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичгийн хамт ачиж өгнө.
- 5.4 Хог хаягдлын дагалдах бичгийг үнэн зөв бөглөсөн байх, хэрэв худал зөрүүтэй мэдээлсэнээс аюул, осол гарах, хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахгүй байх нөхцөл байдал үүсвэл хариуцлагыг тээвэрлүүлэгч хүлээнэ.
- 5.5 Тээвэрлүүлэгч буюу Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 5.6 Аюултай хог хаягдлыг гэрээнд заасан газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь хог, хаягдлыг хүлээн авсан тухай гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан дагалдах бичгийн 2 дах хувийг тээвэрлэгчээс шаардан авах эрхтэй.
- 5.7 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид аюултай хог, хаягдлын талаарх зохих мэдээлэл, зааварчилгаагаар бүрэн хангах үүрэгтэй.
- 5.8 Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэх үед хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэйгээ таарч байгаа эсэхийг хамтран шалгах үүрэгтэй. Хэрэв таарахгүй байвал ачих аюултай хог хаягдлын мэдээллийг үнэн зөв агуулсан дагалдах бичгийг дахин үйлдэж тээвэрлэгчид өгнө.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 3/7

*Тамга*

- 5.9 Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүй байдлыг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.
- 5.10 Аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид зохих журмын хүлээлгэн өгч ачуулсанаар эрсдэл тээвэрлэгчид шилжинэ. Гагцхүү дагалдах бичгийг худал, зөрүүтэй бөглөсөн болон гэрээний 5.9-д заасан нөхцөл байдал үүссэнээс байгаль орчин, хүн, амьтан, эд хөрөнгөд хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

### ЗУРГАА. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэх үүрэгтэй.
- 6.2 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй, хог хаягдлыг тээвэрлэх зориулалт бүхий бүхээгтэй байх ба зохих стандарт нөхцлийг хангасан эвдрэлгүй тээврийн хэрэгслээр аюултай хог, хаягдлыг тээвэрлэх үүрэгтэй.
- 6.3 Тээвэрлэгч нь хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж хүлээн авна.
- 6.4 Тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо, хэмжээнд үл зохицол үүсвэл уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 6.5 Тээвэрлэгч нь аюултай хог, хаягдлыг тээвэрлэхдээ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх ба замын хөдөлгөөний хууль, дүрмийг зөрчсөнөөс тээвэрлүүлэгчид болон бусдад учирсан хохирлыг тээвэрлэгч дангаар хариуцна.
- 6.6 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдсон бусад зардлыг өөрөө дангаар хариуцна. / бензин, моторын тос, тээврийн хэрэгсэлд шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл, хоол хүнс/
- 6.7 Тээвэрлэгч аюултай хог, хаягдлыг хүлээн авснаас хойш хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хог хаягдал алдагдсан, дутсан, гэмтсэн, эвдэрсэн түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хожимдуулсан хариуцлагыг дангаар өөрийн эд хөрөнгөөр хариуцна.
- 6.8 Харин Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүйг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.
- 6.9 Дагалдах бичигт хавсаргасан буюу өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, буруугаар ашигласны хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ.

### ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 7.1 Тээвэрлүүлэгч нь энэ гэрээний 3-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд тээвэрлэгчид төлнө.
- 7.2 Тээвэрлэгч нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй буюу хүлээн авагчид аюултай хог, хаягдлыг хүлээлгэн өгөөгүй бол тээвэрлүүлэгчээс түүнд шилжүүлсэн аюултай хог, хаягдлаа эргүүлэн авах, боломжгүй бол шилжүүлсэн төлбөрөө буцаан шаардах эрхтэй.
- 7.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

### НАЙМ. БУСАД ЗААЛТ

- 8.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 8.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж Талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 8.4 Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 4/7

*Тамъян*



ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Тээвэрлүүлэгч талыг төлөөлж:

"ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий  
инженер

..... П.Болдбаатар

ТЭЗХ-ийн дарга

..... Л.Оюун-Эрдэнэ

Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг  
түр орлол гүйцэтгэгч

..... О.Энхбаяр  
Хими цехийн дарга

..... Е.Цогтбаяр  
Гэрээний мэргэжилтэн

..... Г.Батням

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

..... Ц.Оюун-Эрдэнэ

Суурин утас: (976) 11-343024

Гар утас: 99006727

Регистер: 2546191

УБ гэрчилгээний дугаар:

Химийн бодис ашиглах, импортлох  
тусгай зөвшөөрлийн дугаар: 0002198

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул  
дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн  
чөлөө

Хог хаягдал үүсэх хаяг: "ДЦС-3" ТӨХК

Email хаяг: ps3@tes3.energy.mn

Тээвэрлэгч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн Үйлдвэрийн  
дарга

..... Б.Дарамбазар

Нягтлан бодогч

..... Т.Буяндэлгэр

Суурин утас: : (976) 70189778

Факс: : (976) 70180632

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,

Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх

Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний  
байр

Email хаяг: [Darambazar@tsetsuuh.mn](mailto:Darambazar@tsetsuuh.mn)

Шуудангийн хаяг: ШХ-1138

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 5/7


"Цэцүүх Трейд" ХХК

УЛААНБААТАР ХОГ  
2-3-8-30722

"ХХК-ийн хооронд

байгуулсан Аюултай хог хаягдал тээвэрлэх  
2022 оны 1 дугаар сарын 11-ны өдрийн  
Т-22/01 тоот гэрээний Хавсралт № 01

### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮНИЙН САНАЛ

№	Авто машины нэр төрөл, даац	Авто машины зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ /Төг/
1	Хүнд даац : 25-30 тонн Машины марк: Nord benz, DAF		1км	3900төг
2	Бага даац : 3 тонн Машины марк: ISUZU		1км	2900төг
3	Бага даац : 1 тонн Машины марк: Bongo Fronter		1км	2400төг


#### Тайлбар:

Дээрх тээвэрлэлтийн хөлсөд НӨАТ орсон үнэ болно.

- НҮБ 2020 оны аргачлал, Монгол улсын химийн бодисын тухай хууль, Монгол улсын химийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөлдөлмөр аюулгүй ажилагааг ханган тээвэрлэнэ.
- Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмыг дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын дагуу заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 6/7




**"ДЦС-3" ТӨХК-н АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ  
МАРШРУТ БОЛОН ҮНИЙН САНАЛ**



№	Машины марк даац	Нэг удаагийн тээвэрлэлтийн маршрут	Нийт км	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Бага даац : 1 тонн Машины марк: Bongo Frontier Тээвэрлэлт хийх давтамж: 1удаа	"ДЦС-3" ТӨХК-н захиалгын дагуу УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо хаягтай байршлаас аюултай хог хаягдлыг тээвэрлэн /Төв аймаг Сэргэлэн сум 4- зөрлөг/ нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэх.	2 талд нийт 120км	2400төг	288000төг
<b>Нийт дүн: 576000төгрөг</b>					<b>т</b>



Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 7/7





Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх,  
халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ

№22/Х-10

2022 оны 01-р сарын 03-ний өдөр

4-3-43/22

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас "Элемент медикал" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай Б.Загир, нөгөө талаас ДЦС-3 ТӨХК /цаашид захиалагч гэх/-ыг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай О. Энхбаяр нар харилцан тохиролцож, Иргэний хууль, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах заавар, Эрүүл мэндийн сайдын А/505, А/605 дугаар тушаал болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь захиалагч талаас гарч байгаа аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, халдваргүйжүүлж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

1.3 Гэрээний хавсралт, нэмэлт өөрчлөлт, төлбөрийн нэхэмжлэх, төлбөрийн баримт зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил эрх зүйн үйлчлэлтэй байна.

### Хоёр. Гэрээний хугацаа, төлбөрийн нөхцөл

2.1 Талууд энэхүү гэрээг 2022 оны 01 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаатай байгуулав.

2.2 Талууд гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах тохиолдолд үүссэн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар гэрээний хугацааг өөрчилнө.

2.3 Гэрээгээр гүйцэтгэх ажлын хөлс нь нэг сарын 50 000 (Тавин мянган) төгрөг байх бөгөөд энэхүү дүнг Эрүүл мэндийн сайдын 605 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу тооцно. Ажлын хөлсөнд тусгай зориулалтын эмнэлгийн гаралтай хог хаягдал хийх сав, баглаа боодлын үнэ багтаагүй болно.

2.4 Хог хаягдлыг татан авах цаг хугацааны хуваарь нь 7 хоног, сар бүрийн /Лхагва гаригт/ өдөр татан авалт хийнэ.



2.5 Ажлын хөлсийг тухайн сард эмнэлгийн байгууллагаас гарч буй хог хаягдлын хэмжээнээс үл хамаарч тогтмол дүнгээр, сарын бүрийн 10-ны өдрийн дотор Хаан банкны 5925302960, ХХБанкны 412014804 тоот данснуудын аль нэгэнд төлнө.

#### Гурав. Талуудын эрх үүрэг

- 3.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх,
- 3.2 ЭМС-ын А/505 тоот тушаалуудыг биелүүлээгүй зөрчсөн зэрэг зөрчлийг арилгуулах шаардлага тавьж, биелүүлээгүй тохиолдолд хог хаягдлыг татан авахгүй байх эрхтэй;
- 3.3 А/505 тоот тушаалын 8-р хавсралт ЭМБ аюултай хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагад хүлээлгэн өгөх маягтын үнэн зөв бөглөж, гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулах;
- 3.4 Хог хаягдал ачуулах захиалгыг урьдчилан өгч, ачилт хийгдэх үед хариуцсан ажилтныг ажлын байранд дээр байлгаж, ачилтад хяналт тавих;
- 3.5 Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой байлгах,
- 3.6 Хог хаягдал ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг захиалгын дагуу саадгүй тээвэрлэх;
- 3.7 Өөрийн ажиллагсдын хөдөлмөрийн болон эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллах;
- 3.8 Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагаанаас тээвэрлэлт саатаж хог хаягдал ихээр хуримтлагдах, эмгэг хог хаягдал ихээр гарсан тохиолдолд хуваарьт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч гарган тээвэрлэж халдваргүйжүүлж устгах;
- 3.9 Талууд Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Тусгай зөвшөөрлийн хуулбарын гэрээнд хавсаргах

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа учирсан бодит хохирлыг буруутай тал нөхөн төлнө.
- 4.2 Захиалагч тал графикт хугацаандаа хог хаягдлаа гаргаж өгөөгүй, машин орж хогийг авах боломжгүй, ЭМС-ын А/505 тоот тушаалыг биелүүлээгүй тохиолдолд Мэргэжлийн хяналтын алба, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хандаж гарсан зөрчлийг арилгуулна.
- 4.3 Энэхүү гэрээний 2.4-д заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги тооцож төлнө.
- 4.4 Гүйцэтгэгч нь өөрийн ажиллагсдын болон бусад этгээдийн хөдөлмөрийн болон эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг хангаагүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олгоогүй, аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөрчсөн зэргээс үүдэн өөрсдийн болон Захиалагчийн ажиллагсад, бусад гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцна.


*Тамга*

4.5 Талууд давагдашгүй хүчин зүйл /газар хөдлөлт, үер усны гамшиг зэрэг байгалийн гэнэтийн аюул осол, хориг, дайн байлдаан, халдварт өвчин, эрх бүхий байгууллагын шийдвэр г.м/-ийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг уг саадыг арилах хүртэл хугацаагаар сунгагдсанд тооцох ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

### Тав. Бусад

- 5.1 Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхдээ туслан гүйцэтгэгч авахгүй бөгөөд захиалгат ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.2 Гэрээнд заасан болон бусад зүйлийн талаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрвөл шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

### Гэрээ байгуулсан:



Элемент медикал ХХК-ийг төлөөлж:

Брөнхий нягтлан бодогч: Б.Загир

Хаяг: Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүрэг, 26-р хороо,

Толгойт 6-р хэсэг Их нарангийн 69 тоот

Утас: 99099944, 88813554

Дуудлагын утас: 75050044, 88057656

ДЦС-3 ТӨХК-ийг төлөөлж:

ААЭДэд захирал: /Б. Баянжаргал/

Брөнхий нягтлан бодогч:

/О. Энхбаяр/

Уламжлалт нөхөн сэргээх эмчилгээний

эмч: /Ш. Нармандах/

Гэрээний мэргэжилтэн:

/Г. Батням/

Хяансан:

Хуулийн мэргэжилтэн:

/Оюун-Эрдэнэ/

Харилцах утас: 99026428, 99034665

Хаяг: Улаанбаатар хот-36,

Хан-уул дүүрэг 3-р хороо

БАТЛАВ.

ХУД-ийн "ЭКО ХОТЫН  
ТЭЭВЭР" АНД УГСЫН  
ЗАХИРАЛ *[Signature]* Т. ЧИНЗОРИГТ

БАТЛАВ.

*[Signature]*  
ДУГААР  
ГҮЙЦЭТГЭГЧ  
ЦАХИПГААН СТАНД  
ТӨХК  
ЗАХИРАЛ *[Signature]* Н. Эрхбаатар

ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭР

2022 оны 6 сарын 13 өдөр

№ 22/352 1-2-273/22.

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас 6278558 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, Нөгөө талаас 2546191 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах, СОХ-41 Эрх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2022 оны 6 сарын 13 -ний өдрөөс 2022 оны 10 сарын 30 -ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд ХУД-ийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хороодлын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, мөн нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Айл өрхөөс гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг төлүүлсний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.

- 2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах эрхтэй.
- 2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

#### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал “Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/” хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийн цэг буюу бункерт хийж ачуулах үүрэгтэй.
- 3.3 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай /хашаа/-аас гадагш **50 метрийн** зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байна.
- 3.4 Захиалагч тал нь гэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.5 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул Дүүргийн Татварын Хэлтэс болон [itax.mta.mn](http://itax.mta.mn) сайтаас төлбөрийн даалгавар үүсгэн авч тушаана.
- 3.6 ААН, байгууллагын барилга байгууламжид засвар хийсэнтэй холбогдон гарсан барилгын болон бусад хог хаягдлыг тухай бүрд нь дуудлага өгч буюу захиалгаар тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд хогны хэмжээнээс хамааран нэмэлт төлбөр төлж хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллана.
- 3.7 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг хангана.
- 3.8 Хогийн сав, бункерийн орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.9 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг 2-3 хоногийн өмнө гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 3.10 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.
- 3.11 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.12 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.13 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.14 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.
- 3.15 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.16 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхитэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй.
- 3.17 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.18 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.



#### Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд сард .....<sup>4</sup>.....удаа иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь ХУД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард 82'000 улиралд 246'000 жилд 984'000 төгрөг байна.
- 4.3 E-tax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэж нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө.
- 4.4 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.3-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

#### Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

#### Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

#### Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Найм. Нэмэлт өөрчлөлт

2022 оны .... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Ажлын .....<sup>3</sup>.....дахь өдөр ачилт хийх.

Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

9.1.2 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Арав. Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгч тал:

ХУД-ийн “Эко хотын тээвэр” ААТҮГ:

Гэрээ байгуулсан: Гэрээний мэргэжилтэн

.....<sup>С.Одгэрэл</sup>..... / С.Одгэрэл /

Утас: 88281908

Хороо хариуцсан мэргэжилтэн

1,2-р хороо- 89921220

3,19-р хороо-88063425

20-р хороо-88281908

Захиалагч тал:


Гэрээ байгуулсан:

Албан тушаалтай :

.....<sup>Т.Тангид</sup>..... / Т.Тангид /

Утас:

Хаяг:



Гүйцэтгэх

Л.ЭРХБААТАР



БОАД ХХК-ийн Захирал

О.АЛТАНСҮХ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙЛГЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

2022 оны 03-р сарын 22-ны өдөр

Дугаар 2-3-161/22

Улаанбаатар хот

Нэг талаас "Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас 90114118095 улсын бүртгэлийн дугаар, 5728096 регистрийн дугаартай "БОАД" ХХК (цаашид "Зөвлөх" гэх) нар Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Байгаль орчны аудит хийлгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн ажлын хэсгийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 114/01 тоот хурлын шийдвэр, зөвлөмж, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

1. Үйлчилгээ
  - 1.1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралт 1-д Тодорхойлсон "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ"-нд заасан ажил үйлчилгээг (цаашид "Үйлчилгээ" гэх) үзүүлэх, гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, Захиалагч гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг үүрэгтэй.
  - 1.2. Зөвлөх нь үйлчилгээг үзүүлэхдээ хавсралт 2-т тодорхойлсон "Зөвлөхийн ажиллах хүчний жагсаалт"-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.
  - 1.3. Зөвлөх нь хавсралт 3-т тодорхойлсон "Зөвлөхийн тайлан гаргах хуваарь"-т заасан маягтаар, түүнд товлосон хугацаанд тайлангууд гаргаж захиалагчид ирүүлнэ.
2. Хугацаа
  - 2.1. Зөвлөх нь үйлчилгээг 2022 оны 04-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 05 -р сарын 15-ны хооронд буюу хуанлийн 45 хоногийн хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.
  - 2.2. Талууд гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.
3. Төлбөр
  - 3.1. Төлбөрийн хэмжээ:  
Захиалагч нь зөвлөхөд хавсралт 1-н дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрт төлөх нийт хэмжээ нь 16,083,375.00 (Арван зургаан сая наян гурван мянга гурван зуун далан тав)-н

төгрөг болно. Энэ дүнд НӨАТ болон бусад татвар, хураамж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардал багтсан болно.

3.2. Төлбөрийн хуваарь:

Захиалагч нь ажлыг 100 хувь хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулсны дараа зөвлөхийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн 30 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

4. Захиалагч

4.1. Эрх, үүрэг :

Захиалагч нь Зөвлөхөөс гэрээгээр гүйцэтгэх үйлчилгээг ажлын даалгаварт заасны дагуу гэрээний үнийн дүнд багтаан, Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан, гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

4.2. Захиалагч Зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих, явцын байдалтай газар дээр нь танилцах, санал гаргах, зааварчилгаа өгөх, холбогдох баримт бичиг, мэдээлэл шаардан авах эрхтэй.

4.3. Байгаль орчны аудит хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, захиалагчийн ажлын байр, үйлдвэрийн байранд саадгүй нэвтрэн орох, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх өрөө тасалгаагаар хангах, аудитын нотолгоог баримтжуулах гэрэл зураг авах зөвшөөрөл өгөх, аудитын бэлтгэл үе, газар дээрх аудит хийх аудитын мөрөөр шалгах аудитын үе шатанд бүхий л талаар дэмжлэг үзүүлэх.

4.4. Аудитын үр дүнд илэрсэн үл нийцлүүдийг арилгах арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтийг хариуцах.

5. Зөвлөх

5.1. Эрх, үүрэг:

Зөвлөх нь гэрээгээр гүйцэтгэх үйлчилгээг ажлын даалгаварт заасны дагуу гэрээний үнийн дүнд багтаан, Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан, хугацаанд нь мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд, технологийн дагуу, чанартай шуурхай хийж гүйцэтгэх үүрэгтэй.

5.2. Зөвлөх гэрээнд заасан үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг биелүүлээгүй, гүйцэтгэж буй ажилдаа санаатай буюу болгоомжгүй хандсаны улмаас Захиалагч болон бусдад хохирол учруулсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

5.3. Зөвлөх гэрээ байгуулснаас хойш гэрээнээс татгалзах эрхгүй. Хэрэв дур мэдэн гэрээнээс татгалзах бол үүнтэй холбогдон захиалагчид учирсан шууд болон шууд бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

5.4. Энэ гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээ, гаргасан дүгнэлт, тайлангийн үнэн зөвийг гуравдагч этгээдийн өмнө бүрэн харицах үүрэгтэй.

- 5.5. Гэрээт ажлын хугацаанд өөрийн ажилтнуудын нийгмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг бүрэн хариуцах бөгөөд ГАУСД, ТАД, ААД-г мөрдөж ажиллах.
- 5.6. Гэрээний хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангийн иж бүрэн материал, зөвлөмж, заавар, холбогдох зураг, аргачлал тус бүр цаасаар болон CD 5 хувь мөн PDF файлаар ирүүлэх.
6. Нууцлал 6.1. Зөвлөх нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш зөвлөхийн үйлчилгээ болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай технологийн мэдээллийг, эсхүл захиалагчийн бизнесийн болон үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.
7. Өмчлөл 7.1. Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн Боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамжийн эх хувь нь захиалагчийн өмч болж үлдэнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
8. Даатгал 8.1. Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.
9. Эрх шилжүүлэлт 9.1. Зөвлөх нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.
10. Гэрээнд мөрдөх хууль ба хэл 10.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь Монгол хэл байна.  
10.2. Тендерийн баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно.
11. Маргааныг Шийдвэрлэх, 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.  
11.2. Талууд харилцан тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулж, гэрээнд хавсаргана. Оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.
12. Алданги 12.1. Зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувиар алданги тооцно.  
12.2. Зөвлөх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зохих ёсоор гүйцэтгээгүй болон гүйцэтгэл хангалтгүй гэж Захиалагч үзвэл

гэрээг хугацаанаас өмнө цуцлах, төлбөрийг шилжүүлэхгүй байх, төлөгдсөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхтэй.

13. Давагдашгүй 13.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн 7 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.
- 13.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүргээ гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар сунгагдаж болно.
14. Бусад 14.1. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 14.2. Гэрээг 4 хувь үйлдэж, талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 14.3. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

..... П.БОЛДБААТАР


ТБХ-ИЙН ДАРГА  
..... Г.АМАРТҮВШИН

ЕРӨНХИЙ НЯТЛАН БОДОГЧИЙН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

..... О.ЭНХБАЯР

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН  
..... Г.БАТНЯМ

Хянасан:  
ХУУДИЙН МЭРГЭЖИЛТЭН  
..... Ц.ОЮУН-ЭРДЭНЭ



### Талуудын албан ёсны хаяг:

УБ, ХУД, 3-р хороо  
"ДЦС-3" ТӨХК-ийн байр

Банк: ХХБ 806-р салбар  
Төгрөгийн данс: 406001038  
Факс: 976-11-367288  
Утас: 341990, 344111

УБ, Баянзүрх дүүрэг,  
7-р хороо, 15-р хороолол  
24 - 107 тоот

Банк: .....  
Төгрөгийн данс: .....  
РД: 5728096  
Утас: 91993096

*Handwritten signature*



ТООТ ГЭРЭЭНИЙ НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ


**БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<p>Хууль эрх зүйн үндэслэл:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр заалт</li> <li>2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</li> <li>3. Байгаль орчны аудит хийх аргачлал</li> <li>4. Бусад холбогдох Хууль, дүрэм, журам, заавар</li> </ol>
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	<p>Станцын үйл ажиллагаа нь байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээг авах, экологи эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулах учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээг нарийвчлан тодорхойлоход оршино.</p>
3.	Тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> <li>1. Байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлын туршлагатай бүрэлдэхүүнтэй байгаль орчны аудитын багтай байх;</li> <li>2. Байгаль орчны аудитын багийн гишүүн нь эрх зүй, экологи, байгаль хамгааллын, технологийн чиглэлийн судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай мэргэшсэн боловсон хүчний шаардлагийг хангасан гишүүдтэй байна.</li> <li>3. Байгаль орчны аудит хийх эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй дотоод арга зүйтэй байх;</li> </ol>
4.	Ажлын хамрах хүрээ	<p>“ДЦС-3” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа болон холбогдох алба, хэлтэс, цех, хэсэг нэгжүүд</p>
5.	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>Гэрээнд заасан хугацаанд</p>
6.	Ажлын хяналт, шалгалт	<p>Захиалагч байгууллага ( Хууль эрх зүйн баримт бичиг өөрчлөгдсөн тохиолдолд хамгийн сүүлийн хувилбарыг ашиглах )</p>
7.	Хүлээлгэн өгөх материал	<p>Тайлангийн иж бүрэн материалыг /тайлбар бичиг, зөвлөмж, аргачлал, заавар, холбогдох зураг, CD/ 5 хувийг хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ДЦС-3 ТӨХК / 5 ш /</li> <li>2. Ажлын явц, үр дүнг нэгтгэсэн товч танилцуулга тайлан ( power point )</li> <li>3. Аудитын явцад цуглуулсан материалыг эх файлаар өгөх</li> </ol>

*Handwritten signature*

8.	Захиалагч байгууллага	"Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани
9.	Санхүүжилт, эх үүсвэр	"ДЦС-3" ТӨХК өөрийн хөрөнгө
10.	Ажлын онц-гой нөхцөл	Байгаль орчны аудит хийж байгаа баг нь станцад мөрдөгдөж байгаа аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын үеийн дүрмийг чанд мөрдөн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг бүрэн гүйцэт өмсөж өдөр тутмын зааварчилгаа авч ажиллана.
11.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Холбогдох хуулийг мөрдөнө
12.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцлөөр гэрээний үндсэн төлбөрт тооцон гүйцэтгэнэ.







хоёрдугаар хавсралт

### АУДИТ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр	Албан тушаал	Туршлага	Хариуцах ажил
1	О.Алтансүх	Ахлах аудитор	20	Багийн удирдлага, усан орчны менежмент
2	Д.Даваадорж	Аудитор	15	Хөрсөн орчин ба газрын менежмент
3	Б.Ариунсанаа	Аудитор	12	Агаар орчин, хийн ялгаруулалтын менежмент
4	Н.Оюунчимэг	Аудитор	9	Хог хаягдлын менежмент
5	Б.Баярмаа	Аудитор	28	Хими болон аюултай бодисын менежмент
6	Ч.Оюундарь	Аудитор	10	Биологийн олон янз байдлын менежмент



**“БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ БОЛОМЖУУД” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

№ 4-4-336/22

2022 оны 10-р сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот.

Монгол улсын Иргэний хуулийн холбогдох заалт, 2022 оны “ДЦС-3” ТӨХК-ийн ажилтнуудын сургалт хөгжлийн тодотгосон төлөвлөгөөг үндэслэн энэхүү гэрээг нэг талаас “ДЦС-3” ТӨХК /цаашид “Захиалагч” тал гэх/-ийг төлөөлж Ерөнхий инженер П.Болдбаатар, нөгөө талаас /цаашид “Гүйцэтгэгч” тал гэх/ “Олон Улсын Стандартын Академи” ХХК-ийн Сургалтын менежер Г.Болормаа нар харилцан тохиролцсоны үндсэн дээр доорхи нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь “ДЦС-3” ТӨХК-ийн ашиглалтын 4 ээлжийн ажилчид, 100 ИТА-д **“БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ БОЛОМЖУУД”** сэдэвт 2 цагийн сургалтыг 3 удаа зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход оршино.
- 1.2. Гэрээт сургалтыг зохион байгуулах хугацаа: 2022 оны 10-р сарын 6, 7-ны өдрүүдэд Соёлын төвийн хурлын зааланд зохион байгуулна.

**Хоёр. Төлбөр, тооцоо**

- 2.1 Гэрээт 1 цагийн сургалтын төлбөр 200.000 /хоёр зуун мянга/-н төгрөгөөр тооцож, нийт төлбөр нь 1,200,000.00 /нэг сая хоёр зуун мянга/-н төгрөг байна.
- 2.2 Сургалтын төлбөрийг сургалт зохион байгуулж дууссаны дараа гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан гүйцэтгэгчийн ХХБ-ны 431002828 тоот дансанд нэхэмжлэхээр шилжүүлнэ.

**Гурав. Гүйцэтгэгч талын эрх үүрэг**

- 3.1 Сургалтыг гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд зохион байгуулна.
- 3.2 Сургалтын хөтөлбөрийг урьдчилан гаргаж Захиалагч талд танилцуулан уг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах үүрэгтэй.
- 3.3 Сургалтыг чанартай зохион байгуулах тал дээр анхаарал тавьж энэ талаар Захиалагч талд санал гаргах эрхтэй.
- 3.4 Хийж гүйцэтгэсэн гэрээт ажлынхаа гүйцэтгэлийн хэмжээнд тохирсон хөлс төлөхийг шаардах эрхтэй.

**Дөрөв. Захиалагч талын эрх үүрэг**

- 4.1. Сургалтыг зохион явуулах тоног төхөөрөмж бүхий анги танхимаар хангана.
- 4.2 Сургалтанд хамрагдаж буй ажилтнуудад хяналт тавьж, бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

- 4.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд гэрээг цуцалж, учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
- 4.4. Сургалтын явцыг хянаж, зөвлөлдөх эрхтэй.

#### Тав. Хариуцлага

- 5.1. Хоёр тал гэрээнд тусгагдсан заалтуудыг чанд мөрдөж ажиллана.
- 5.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ мэдэгдэнэ.
- 5.3. Гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотойгоор талуудын гаргасан шаардлагыг нөгөө тал хүлээн авч нэн даруй хариу мэдэгдэх үүрэгтэй.
- 5.4. Талууд гэрээнд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 5.5. Гэрээт сургалтыг батлагдсан хөтөлбөрт хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,2%-ийн алдангийг захиалагч талд хоног тутам төлнө. Нийт алдангийн хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 20%-иас хэтрэхгүй байна.

#### Зургаа. Бусад зүйл

- 6.1 Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээ хэрэгжиж дууссанаар дуусгавар болно.
- 6.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож энэ гэрээнд хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэг адил хууль зүйн хүчинтэй.
- 6.3 Гэрээний талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс гэрээг цаашид үргэлжлүүлэх боломжгүйд хүрвэл нөгөө тал гэрээг цуцлах санал гаргаж болно.
- 6.4 Гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд 3 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 6.5 Гэрээг 3% үйлдэж гүйцэтгэгч тал 1%, захиалагч тал 2%-ийг хадгалах ба хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### Захиалагчийг төлөөлж:

"ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий  
инженер  
..... П.Болдбаатар

ЗХНА-ны дарга  
..... Э.Мөнхшүр

СБХ-ийн дарга  
..... Л.Доржхорлоо

Гэрээний мэргэжилтэн  
..... Г.Батням

Хуулийн мэргэжилтэн  
..... Ц.Оюун-Эрдэнэ

Сургалтын инженер  
..... О.Эрдэнэцэцэг

##### Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Олон Улсын Стандартын  
Академи" ХХК-ийн Сургалтын  
менежер

..... Г.Болормаа

Сургалч багш  
..... Б.Бүжидмаа

УБ хот, БЗД, Токио тауэр  
504 тоот

РД: 6141129

Утас: 76009218, 91117795

99144402



**“БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ  
БОЛОМЖУУД” СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2022.09.22

Сургалт зохион байгуулах газар: “ДЦС-3” ТӨХК

Сургалт явуулах хугацаа: 2 цаг x 3 удаа


№	Сургалтын сэдэв	Хугацаа	Сургагч багш
1	Дэлхийн болон Монгол орны хүрээлэн буй орчны асуудал, өнөөгийн чиг хандлага	30мин	Б. Бүжидмаа
2	Байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжийн талаарх ерөнхий ойлголт	20 мин	Б. Бүжидмаа
3	Эрчим хүчний салбараас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллүүд	20 мин	Б. Бүжидмаа
4	Дулааны цахилгаан станцаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай	30 мин	Б. Бүжидмаа
5	Эрчим хүчний эх үүсвэрийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулсан болон сайн туршлага	20 мин	Б. Бүжидмаа


Хөтөлбөр гаргасан:

Сургалтын менежер: **Болормаа**

Баталсан: Н.Уранчим

Гүйцэтгэх захирал






ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ

Д.ЭРХБААТАР



БАТЛАВ:

"ЭКО ГИДРО ПРОЕКТ" ХХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ГАНСҮХ

**ҮНСЭН САН №4, 5-Г ДАХИН АШИГЛАХ ЗУРАГ, ТӨСӨВ, МАГАДЛАЛ  
ХИЙЛГЭХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2022 оны 05-р сарын 18-ны өдөр

Дугаар 2-3-248/22

Улаанбаатар хот

Нэг талаас "Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас 9011811131 улсын бүртгэлийн дугаар, 6470181 регистрийн дугаартай "Эко гидро проект" ХХК (цаашид "Зөвлөх" гэх) нар Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, ДЦСЗ/202201097 дугаартай тендерийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын 097/03 тоот тэмдэглэл, 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 097/03 тоот зөвлөмж, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

- |              |   |
|--------------|---|
| 1. Үйлчилгээ | 1.1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д Тодорхойлсон "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ"-нд заасан ажил үйлчилгээг (цаашид "Үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.  |
|              | 1.2. Зөвлөх нь үйлчилгээг үзүүлэхдээ тендерийн баримт бичигт дурдсан "Зөвлөхийн ажиллах хүчний жагсаалт"-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.   |
|              | 1.3. Зөвлөх нь тендерийн баримт бичиг дурдсан "Зөвлөхийн тайлан гаргах хуваарь"-т заасан маягтаар, түүнд товлосон хугацаанд тайлангууд гаргаж захиалагчид ирүүлнэ.  |
| 2. Хугацаа   | 2.1. Зөвлөх нь үйлчилгээг 2022 оны 05-р сарын 09-ны өдрөөс 2022 оны 10-р сарын 01-ний хооронд тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ.   |
| 3. Төлбөр    | 3.1. <u>Төлбөрийн дээд хэмжээ:</u><br>Захиалагч нь зөвлөхөд Хавсралт 1-н дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрт төлөх дээд хэмжээ нь 65,150,000.00 (Жаран таван сая нэг зуун тавин мянга)-н төгрөг болно. Энэ дүнд зөвлөхийн бүх зардал, ашиг мөн түүнчлэн зөвлөхөд ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно. |
|              | 3.2. <u>Төлбөрийн хуваарь:</u><br>Захиалагч нь ажлыг 100 хувь хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулсны дараа зөвлөхийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн төлбөрийг шилжүүлнэ.  |

- 3.3. Төлбөрийн нөхцөл:  
Төлбөрийг 4 дүгээр зүйлд заасан төлбөрийн нэхэмжлэхийн хувийг төслийн зохицуулагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор төгрөгөөр хийнэ.
- 3.4. Тайлан:  
Зөвлөх нь Хавсралт 3-т тодорхойлсон "Зөвлөхийн тайлан гаргах хуваарь" –т заасан тайланг хуваарийн дагуу ирүүлэх бөгөөд энэ нь 3 дугаар зүйлийн дагуу төлбөр хийх үндэслэл болно.
4. Гүйцэтгэлийн
- 4.1. Зөвлөх нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр чанар түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу Зөвлөхийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол зөвлөх уг ажилтныг нэн даруй солино.
- 4.2. Ажлын зурагт холбогдолтой бүх зураг, төсөв, ажлын тоо хэмжээг тус бүр цаасаар 3 хувь болон PDF файлаар ирүүлнэ.
- 4.3. Уг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгэсэн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг хэрэгжүүлэх явцад гарсан зөвлөх үйлчилгээний алдаа гарсан тохиолдолд зөвлөх хариуцан үнэ төлбөргүйгээр заасан хугацаанд засварлана.
5. Нууцлал
- 5.1. Зөвлөх нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш зөвлөхийн үйлчилгээ болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай технологийн мэдээллийг, эсхүл захиалагчийн бизнесийн болон үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.
6. Өмчлөл
- 6.1. Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн Боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамжийн эх хувь нь захиалагчийн өмч болж үлдэнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
7. Даатгал
- 7.1. Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.
8. Эрх шилжүүлэлт
- 8.1. Зөвлөх нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.
9. Гэрээнд мөрдөх хууль ба хэл
- 9.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь Монгол хэл байна.
- 9.2. Тендерийн баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно.
10. Маргааныг шийдвэрлэх
- 10.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

11. Алданги

11.1. Гэрээний дагуу ажлыг гүйцэтгэх явцад захиалагчаас шалтгаалж гэрээнд заасан хугацаанд төлбөр тооцоог барагдуулаагүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувиар алданги тооцно. Зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувиар алданги тооцно.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ,  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
..... П.БОЛДБААТАР

ТБХ-ИЙН ДАРГА  
..... Г.АМАРТҮВШИН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
..... О.ЭНХБАЯР

ӨДЗЦЕХИЙН ДАРГА  
..... Ц.БАТТӨГС

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН  
..... Г.БАТНЯМ

Хянасан:  
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
..... Ц.ОЮУН-ЭРДЭНЭ


**ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

..... Э.НАНДИН-ЭРДЭНЭ

Хан-Уул дүүрэг 3-р хороо  
"ДЦС-3" ТӨХК-ийн байр  
Факс: 343024

Утас: 341990, 344111  
Банк: ХХБ 806-р салбар  
Төгрөгийн данс: 406001038

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
их тойруу, Үндэсний шуудан сонины  
байр  
РД: 6470181  
Банк: *Талармт*  
Төгрөгийн данс: *14115131903*  
Утас: 98115454



ТООТ ГЭРЭЭНИЙ НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

**“ДЦС-3” ТӨХК-ИЙН ХУУЧИН ҮНСЭН САНТ №4,5-Н ҮНСИЙГ СУЛЛАЖ ШОРООН ДАЛАНГ ДАХИН АШИГЛАХ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ МАГАДЛАЛ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<p>1.1 “ДЦС-3” ТӨХК нь 2021 онд өөрийн эзэмшлийн 9.3 га газарт шинэ үнс хадгалах санг бариулан ашиглалтад хүлээн авсан. Тус үнсэн сангийн ашиглалтын хугацаа дуусахаас өмнө дараагийн ашиглах үнс хадгалах санг урьдчилан бэлдэх.</p> <p>1.2 Өмнө ашиглаад дүүргэсэн үнс хадгалах сан №4,5-н үнсийг суллан шороон даланг дахин ашиглаж үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад оршино.</p> <p>1.3 Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр “ДЦС-3” ТӨХК-ийн ӨДСтанц, ДДСтанцын өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдэхтэй холбогдуулан бэлтгэл ажил хангах.</p>
2.	Байршил	<p>2.1 Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3,4-р хороо “ДЦС-3” ТӨХК-ийн баруун талд</p>
3.	Объектийн бүрэлдэхүүн хүчин чадал	<p>Үнс хуримтлуулах геотехникийн байгууламж тоноглолын хамт: (Хуучин үнс хадгалах сан №4,5 тус бүрт)</p> <p>3.1 Шороон даланг нэг үе ус, хий үл нэвтрүүлэх геотор, геотекстель, геомембранаар бүхэлд нь доторлохоор зураг, гаргах.</p> <p>3.2 Далангийн өнөөгийн нөхцөл байдалд бодит хэмжилт хийж шаардлагатай бараа материалын тоо хэмжээ гаргах.</p> <p>3.3 Тунгагдсан усыг тунгаах сан руу авах, бүрэн битүүмжлэн хаах боломжтой шандорын хоёр худаг зам, тавцангийн хамт төлөвлөх.</p> <p>3.4 Үнс хадгалах санд үнс усны холимог хаях зориулалттай хаялагын шугам, тулгууруудын хамт төлөвлөх.</p> <p>3.5 Хуучин үнс хадгалах сан №4,5-н шороон далан, дагалдах байгууламжуудад хэмжилт хийн ашиглах явцад газар хөдлөлтийн 8.0 баллд тэсвэртэй байх арга хэмжээг төлөвлөж тусгах.</p> <p>3.6 Тус бүр нь 950,000 м3 багагүй эзэлхүүнтэй байхаар ажлын зураг гаргах.</p>



4.	Инженерийн байгууламж бүрэлдэхүүн буюу ажлын зураг төслийн бүрдэл	<p>4.1 Хуучин үнс хадгалах сан №4,5-г суллахад гарах үнсийг зөөж шилжүүлэн хаях газрын байршил, цэгийг эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөн зөвшөөрөл авах.</p> <p>4.2 Үнс хадгалах санд хуримтлагдсан үнсийг дахин ашиглах технологи судалж тодорхой хэсгийг эргүүлэн ашиглах.</p> <p>4.3 Хуучин үнс хадгалах санг ямар технологиор ухах, хаанаас нь эхлэх, машин техник явах зам гарц, ачилт, аюулгүй ажиллагааны арга хэмжээг тооцох.</p> <p>4.4 Инженер геологийн дүгнэлт гаргах.</p> <p>4.5 Үнс хадгалах сан №4,5-аас тунгаах сан руу буцах 800 мм хоолойн траншей, трассыг нарийвчлан тооцож шийдэл гаргах.</p> <p>4.6 Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс, 2 хувь ажлын график зураглал, CD-ны хамт захиалагчид, үлдсэн хувийг архивт өгнө.</p> <p>4.7 Ажлын зургийг хамгийн сүүлийн үеийн албан ёсны програм хангамж ашиглах UTM координатын системд хийж гүйцэтгэн зураг, төсөвт холбогдох мэргэжлийн төв, зөвлөх, экспертээр магадлалын дүгнэлт гаргуулах</p>
5.	Эдийн засгийн тооцоо, төсөв.	<p>5.1 Хуучин үнс хадгалах сан №4,5 тус бүрт ажлын төсөв гаргах.</p> <p>5.2 Төсвийг ESTIMATOR -PRO программ болон түүнтэй дүйцэхүйц зохих эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн бусад программаар тооцно.</p> <p>5.3 Төсөвийг хийхдээ нэг үнс хадгалах санг суллах төсөөлөл, тээвэрлэх боломж, цаг уурын нөхцөл байдлыг судлан жил дамнан гүйцэтгэхээр тооцож гаргах.</p> <p>5.4 Үнс хадгалах сангийн доторлогооны доор цооролтоос хамгаалж дэвсэх элсний оронд үнсийг ашиглахаар тооцож бараа материалын тоо хэмжээ, төсөв гаргах.</p> <p>5.5 Хуучин үнс хадгалах сангаас гарч буй үнсийг Улаанбаатар хотоос зөөж шилжүүлэхэд гарах тээврийн зардлыг тус бүрт нь тооцож гаргах. ( Жич: 20-40 км зай тус бүрээр )</p> <p>5.6 Хуучин сангуудаас аль санг түрүүлж ашиглавал эдийн засгийн үр ашигтай байгааг харьцуулан гаргах.</p>
6.	Зураг, төсөл зохиох үе шат	<p>6.1 Бэлтгэл ажил</p> <p>6.2 Инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга</p> <p>6.3 Зураг, төсөл боловсруулах</p> <p>6.4 Ажлын зураг, төсөв хийж магадлалаар баталгаажуулах</p>
7.	Ажлын зураг, төсөв баталгаажуулах байгууллага	<p>7.1 Ажлын зураг төсөв зохиосон гүйцэтгэгч нь "Барилгын хөгжлийн төв"-өөр магадлал баталгаажуулалт хийлгэн гэрээний хугацаанд захиалагчид хүлээлгэн өгнө.</p>
8.	Зураг, төсөл боловсруулах хугацаа	<p>8.1 Анхны гэрээнд заасан хугацаа, төсөвт</p>
9.	Захиалагч байгууллага	<p>9.1 "ДЦС-3" ТӨХК</p>
10.	Гүйцэтгэгч байгууллага	<p>10.1 Тендерт шалгарсан компани</p>

11.	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд зураг төсөлд тавигдах шаардлага:</p> <p>11.1 Эрчим хүчний тухай хууль  11.2 Байгаль орчныг хамгаалах тухай хууль  11.3 Ашигт малтмалын тухай хууль  11.4 Газрын тухай хууль,  11.5 Усны тухай хууль  11.6 Газрын хэвлийн тухай хууль  11.7 Зөрчлийн тухай хууль  11.8 Барилгын тухай хууль  11.9 Хог хаягдлын тухай хууль  11.10 Агаарын тухай хууль  11.11 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай хууль</p> <p>Барилгын норм ба Дүрэм:</p> <p>11.12 Зам, далан БНБД 32.02.00  11.13 Шугам сүлжээ БНБД 3.05.03.95  11.14 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23.01.09  11.15 БНБД 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам  11.16 БНБД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь  11.17 БНБД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл  11.18 БНБД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц  11.19 БНБД 33-07-09 Шороон боомт  11.20 БНБД 50-02-17 Барилгын газар шороо ба буурь суурийн ажил  11.21 БНБД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт  11.22 "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Техникийн ерөнхий шаардлага  11.23 Төсөв зохиох аргачлал  11.24 Агаарын чанарын шаардлага стандарт  11.25 Бусад холбогдох стандарт, норм дүрмүүд</p>
12.	Онцгой нөхцөл	<p>12.1 Байгууламжийн хамгаалалтын зурвасын зай хэмжээг "Эрчим хүчний инженерийн байгууламж, шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн шаардлагыг хангахаар зураг гаргах.  12.2 Ажлын зураг, төсөв боловсруулах шатанд холбогдох хууль, дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдолд сүүлийн хувилбараар засаж хүлээлгэн өгнө.  12.3 Байгууламжийг барихад дайрч гарах зам сүлжээг тооцох.  12.4 Ажлын зураг, төсөв зохиох шатанд хууль, дүрэм, тогтоол шийдвэрүүдийн заалттай зөрчилдөх нөхцөл байдал үүсвэл зөвлөх хуулийн эдгээд нь мэргэжлийн ур чадвар гарган шаардлагатай бол эрх бүхий байгууллагуудыг мэдээллээр ханган зөвшилцөж ажлын зураг, төсөвийг нэмэлт зардал гаргахгүйгээр батлуулах үүрэг хүлээнэ.</p>



## “ДЦС-3” ТӨХК-ИЙН ХАМТ ОЛОН ТУУЛ ГОЛ ЦЭВЭРЛЭХ АЯНД НЭГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.07.19

### Ажлын зорилго:

Дулааны гуравдугаар цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компанийн хамт олон Эрчим хүчний салбарын 100 жилийн ой, нийгмийн хариуцлагын хүрээнд Туул голын эрэг дагуух их цэвэрлэгээг бүх алба, хэлтэс, цех, хэсгүүдээс бүрдсэн 100 хүний бүрэлдэхүүнтэйгээр Яармагийн гүүрнээс Сонсголонгийн гүүр хүртэлх талбайд их цэвэрлэгээ хийж хариуцагч Туул голын сав газрын захиргаа, дүүргийн холбогдох хүмүүст танилцуулсан.

### Их цэвэрлэгээ хийсэн талбай:

#### “ДЦС-3” ТӨХК    ТУУЛ ГОЛЫН ЦЭВЭРЛЭГЭЭ 2022 ОН





**Ажлын гүйцэтгэлийн зураг:**



Зураг-1 Станцын ажилтнууд аянд нэгдэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авав



Зураг-2 Цэвэрлэгээ хийх талбай руу явж буй байдал



Зураг-3 Голын эрэг дагуу цэвэрлэгээ хийж буй байдал



Зураг-4 Голын эрэг орчмын гялгар уут, хуванцар сав цэвэрлэв



Зураг-5 Голын эрэг дагуу гэр ахуйн хуучин хэрэгсэл хаясан байсанг цэвэрлэв.



Зураг-6 Цэвэрлэгээний ажил үргэлжилсээр...



Зураг-7 Сонсголонгийн гүүр орчмын талбайн цэвэрлэгээ



Зураг-8 Сонсгологийн гүүрний зүүн талын цэвэрлэгээ



Зураг-9 Сонсголонгийн гүүрний зүүн талыг цэвэрлэв.



Зураг-10 Яармагийн гүүрний баруун талыг цэвэрлэв.





Зураг-11 Ажлаа дуусгаад селфи хийв




Зураг-12 ТГСГЗ, ХУДүүрэгтэй холбогдож цэвэрлэгээний хогийг ачуулав.



Зураг-13 Их цэвэрлэгээгээ дуусгасан хэсэг ажилтнууд патериаа татуулав.

“ДЦС-3” ТӨХК-иас жил бүр тогтмол Хавар-Намрын их цэвэрлэгээг бүх ажилтнуудаа хамруулан хийж хэвшсэн. Энэ жил Намрын их цэвэрлэгээг “Хоггүй Хан-Уул 2022” аяны хүрээнд, байгаль, нийгмийн орчноос хүн амын эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ил задгай хог хаягдал ихээр үүсэх, хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12 т заасны дагуу 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн хил хязгаар хүртэлх мөн компанийн ариун цэврийн журмыг хэрэгжүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 28 буюу Баасан гаригт хийсэн. Жич: Хавар, намрын цэвэрлэгээ хийсэн зургууд хавсаргав.



Зураг-14 Станцын гадна талбайд хавар цэвэрлэгээ хийж буй байдал



Зураг-15 Станцын гадна авто машины зогсоол орчим цэвэрлэгээ хийв



Зураг-16 Станцын хойд гадна талбай цэвэрлэж буй байдал



Зураг-17 Станцын гадна цахилгаан дамжуулах агаарын шугам орчим цэвэрлэв.



Зураг-18 Станцын гадна байрлах дулааны шугам хоолойн орчим цэвэрлэв



Зураг-19 Зуны улиралд хашаан дотор ургасан шарилжыг цэвэрлэж буй байдал



Зураг-20 Хашаан доторх хуваарьт талбайгаа цэвэрлэж буй цехийн ажилтнууд




Зураг-21 Станцын гадна талбайд бөөгнүүлсэн хогийг өөрсдийн автомашинд ачиж хогийн цэг рүү явуулж буй байдал



Зураг-22 Үнс хадгалах сангийн ашиглалтын байдал / 2022.05 сар /



Зураг-23 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын мэргэжилтэнүүд Станц болон  
Тунгаах усны насос станцын үйл ажиллагаатай танилцав



Зураг-24 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу Байгаль орчны хэмжил зүйн төв лаб-р агаарын чанарын хэмжилт хийлгэв.



Зураг-25 Станцын урд байрлах хотхоны орчим агаарын чанарын хэмжилт хийлгэв.





Зураг-26 Байгаль орчны аудитын хүрээнд үнс хадгалах сангийн ойролцоо хэмжилт хийгдэв



Зураг-27 Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраар хуучин үнс хадгалах сангийн орчмоос хөрсний дээж авхуулав.



Зураг-28 Станцын зүүн урд талд агаарын чанарын хэмжилт хийлгэв.



Зураг-29 Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас ажиллагаанд байгаа үнс хадгалах сангийн ойролцоо хөрсний дээж авав.



Зураг-30 Ажиллагаанд байгаа үнс хадгалах сангийн хажууд агаарын чанарын шинжилгээ хийлгэв.



Зураг-31 Станцын яндангийн хажуугийн хөрснөөс дээж авч шинжилгээнд хамруулав.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ТБХ-09-2015



Зураг-32 Ажиллагаанд байгаа үнс хадгалах санд усан толио, үе үүссэн байдал



Зураг-33 Станцын хашаан доторх ногоон байгууламж зүлэгжүүлэлт зуны улиралд харагдах байдал